



ЖИЛИЙН ТАЙЛАН 2007

Нээлттэй Нийгэм Форум

ГАРЧИГ

ӨМНӨТГӨЛ 3

Форумын үйл ажиллагааны чиглэл

ЗАСАГЛАЛ

- Ил тод байдал 5
- Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө 6
- Нээлттэй ил тод төсөв 8
- Төрийн үйлчилгээний мониторинг 10
- Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга 12
- Иргэдийн оролцоо ба мэдээллийн эрх чөлөө 15
- Эрх зүйн туслалцаа 17
- Стратегийн өмгөөлөл 18
- Төрийн бус байгууллагын эрх зүйн зохицуулалт 19

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- Эдийн засгийн эрх чөлөөний индекс 20
- Монгол Улсын өрсөлдөх чадвар 23
- Орон нутгийн эдийн засгийн хөгжил 24
- Уул уурхайн салбарын бодлогын асуудал 26
- Газрын шинэтгэлийн хэрэгжилт 27
- Хөгжлийн бодлогын яриа хэлэлцүүлэг 27

НИЙГМИЙН БОДЛОГО

- Боловсрол, нийгмийн асуудлууд 29

Форумын үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэрэгсэл

- ХӨГЖЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТӨВ 31
- ПОРТАЛ САЙТ 33
- БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР 36
- ЭРДМИЙН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР 38
- ХЭВЛЭН НИЙТЛЭЛ 39
- ОРЧУУЛГЫН ТӨСӨЛ 40

БУСАД ХАВСРАЛТ

- Дорно Дорно хөтөлбөр 41
- Санхүүгийн тайлан 43
- Ажилтнууд 49



ӨМНӨТГӨЛ

Нээлттэй Нийгэм Форум улс орныхоо хөгжил цэцэглэлд өөрийн хувь нэмрээ оруулахыг хичээж, төрийн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлж, ардчилсан төрөө бэхжүүлэхэд төрийн бус болон төрийн байгууллагуудтай нягт хамтран ажиллахыг зорьж ирлээ. 2007 он Монголын хувьд нийгэм, улстөр, эдийн засгийн олон чухал үйл явдлаар дүүрэн жил байлаа. Авилгын эсрэг хууль хэрэгжиж эхэлснээр Монголын түүхэнд анх удаа төрийн өндөр албан тушаалтнууд хөрөнгө, орлогоо олон нийтэд ил тод мэдээлсэн нь энэ оны онцлох үйл явдал боллоо.

Төрийн ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд Нээлттэй Нийгэм Форум иргэний нийгмийн зүгээс төрд тавих хөндлөнгийн хяналтыг сайжруулахад дэмжлэг болгон 60 гаруй төрийн бус байгууллагад арга зүйн болоод санхүүгийн туслалцаа үзүүлж төрийг хяналттай байлгах иргэний нийгмийн чадавхийг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулж байна. Төрийн байгууллагуудын ил тод байдлыг дээшлүүлэх талаар 2006 онд зохион байгуулсан төр, иргэний нийгмийн форумаас гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг иргэний нийгмийн байгууллагууд хэлэлцэж, зөвлөмжийг шинэчлэн олон нийтийн сонорт хүргэсэн нь дээрх зорилгыг хэрэгжүүлэх бас нэг үр дүн болжээ. Нөлөөллийн цогц үйл ажиллагааны үр дүнд хууль боловсруулах явцын ил тод байдлыг хангах зорилгоор

УИХ-ын үйл ажиллагаан дахь иргэдийн оролцоог бүрдүүлэх хуулийн төслүүд өргөн баригдсан болно.

Шинээр байгуулагдсан Авилгатай Тэмцэх Газрын авилгаас урдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр гаргаж буй санал санаачилгыг нь дэмжлээ. Тухайлбал, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод, шуурхай байдлыг хангах талаар АТГ-аас гаргасан зөвлөмжийн хэрэгжилтэд мониторинг хийлгэсний зэрэгцээ иргэдийн санал гомдлыг хүлээн авах шуурхай утас ажиллуулсан нь төрийн байгууллагуудын зүгээс иргэддээ мэдээллээр шуурхай үйлчилдэг болоход зарим түлхэц боллоо.

Улс орны эдийн засгийн хөгжлийн гол тулгуур эх үүсвэрийн нэг болох уул уурхайн салбар сүүлийн гурван жилийн турш Монголын нийгмийн анхаарлын төвд байлаа. Нээлттэй Нийгэм Форум 2007 онд томоохон төслүүдийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын хувилбаруудыг тодорхойлоход түлхүү анхаарч, Хөрөнгө оруулалтын гэрээнүүдэд иж бүрэн дүн шинжилгээ хийж, иргэний нийгмийн байгууллагуудын дунд яриа хэлэлцүүлэг өрнүүлэв. Уул уурхайн салбар дахь төрийн өмчийн оролцоо, гэнэтийн ашгийн татвар, төсөв санхүүгийн тогтолцоо зэрэг олон асуудлаар хийсэн бидний судалгаа энэ чиглэлээр үндэсний хэмжээнд өрнөж буй хэлэлцүүлэгт хувь нэмрээ оруулсан гэдэгт итгэлтэй байна. Цаашлаад

Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилгыг бодит ажил хэрэг болгохын төлөө Нээлттэй Нийгэм Форум өөрийн хүч чадлаа дайчлан ажилласан агаад манай улсад уул уурхайн чиглэлээр хайгуулийн болон ашиглалтын үйл ажиллагаа эрхлэхээр олгогдсон бүхий л лицензийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл Форумын дэмжлэгтэйгээр энэ онд олон нийтэд анх удаагаа хүрснийг дурдах нь зүйтэй бизээ.

Нээлттэй Нийгэм Форум 2007 онд орон нутгийн төсвийн тогтолцоог бэхжүүлэх, төвлөрлийг сааруулах чиглэлд нөхцөл байдлын үнэлгээ хийх, хөтөлбөр боловсруулах ажлыг гүйцэтгэсний зэрэгцээ хөдөө, орон нутгийн түвшинд төсвийн мэдээллийг ил болгох үүднээс Ховд аймгийн болон бүх сумын нь төсвийн талаарх мэдээллийг бэлтгэж иргэдэд танилцуулсан нь үр дүнтэй ажил боллоо. Түүнчлэн сумдын түвшинд бодлогын шинэчлэл хийн хувийн хэвшлийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг

боловсруулах зорилготой ДЕЛТА төслийг Хөвсгөл аймгийн Тариалан, Архангай аймгийн Ихтамир, Увс аймгийн Тариалан, Баянхонгор аймгийн Баянхонгор сумдад хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, чухал ач холбогдолтой төслүүдийг санхүүжүүлэх “Хөрөнгө оруулалтын сан” -г байгуулалцав.

Энэ мэт хийж бүтээсэн, бүтээхийг оролдон зорьж яваа үйл хэргээ Та бүхэнд толилуулж буйдаа таатай байна. Эрхэм Та Нээлттэй Нийгэм Форумаас авч хэрэгжүүлсэн, санаачилсан, санхүүжүүлсэн, иргэний нийгмийн бусад байгууллагатай хамтран гүйцэтгэсэн арга хэмжээ, үйл ажиллагааны талаар санал сэтгэгдлээ хуваалцах аваас бид талархан хүлээн авах болно.

*Нээлттэй Нийгэм Форумын
гүйцэтгэх захирал*

П.Эрдэнэжаргал



ЗАСАГЛАЛ

ИЛ ТОД БАЙДАЛ

2006 онд “Авилгын эсрэг хууль” батлагдан авилгатай тэмцэх байгууллага /Авилгатай Тэмцэх Газар/ бий болсноор авилгаас урьдчилан сэргийлэх талаар зарим тодорхой алхмууд хийгдэж эхэллээ. 2007 онд Монголын түүхэнд анх удаа төрийн өндөр албан тушаалтнууд хөрөнгө орлогоо мэдүүлж, тэдний орлого олон нийтэд нээлттэй боллоо.

Нээлттэй Нийгэм Форум төрийн ил тод байдлын асуудлыг хөндсөн, олон нийтийн оролцоотой анхны форумыг “Төрийн ил тод байдал: Нийгмийн баялгийн хуваарилалт” сэдвээр 2006 оны 12 дугаар сарын 7-нд зохион байгуулж, цаашид авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээний талаар зөвлөмж гаргасан билээ. Энэхүү форумын санал

дүгнэлтүүд нь төрийн байгууллагуудад хандаж үйл ажиллагааныхаа ил тод байдлыг хангах, үйлчилгээг түргэн шуурхай болгох талаар Авилгатай Тэмцэх Газраас гаргасан зөвлөмжид тусгалаа олсон юм. Иймээс Нээлттэй Нийгэм Форум уг зөвлөмжийг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх үүднээс олон нийтэд таниулах, хэрэгжилтэд нь мониторинг хийх ажлыг санхүүжүүлээ. Төслийн хүрээнд шуурхай утас ажиллуулах, үнэлгээ өгөх, төрийн үйлчилгээний ил тод байдлыг шаардах талаар иргэдэд мэдээлэл өгөх үйл ажиллагаа явагдсан байна. 2007 оны 11-12 дугаар саруудад Иргэний нийгмийн цуврал форумыг зохион байгуулж, 2006 оны форумаас гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг дүгнэн хэлэлцээд дахин шинэчилж



холбогдох байгууллагуудад хүргэв.

“Төрийн ил тод байдал” форумыг хоёр дахь удаагаа “Шударга сонгууль” сэдвийн дор 2007 онд зохион байгуулж сонгуулийн асуудлыг авч хэлэлцүүлээ. 12 дугаар сарын 12-ний өдөр болсон энэ форумгаар УИХ-ын сонгуулийг шударга явуулахтай холбоотой бүхий л асуудлыг холбогдох талууд нарийвчлан хэлэлцэж тодорхой зөвлөмж гаргасан бөгөөд үүний заримхэсэг нь Сонгуулийн хуулинд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд тусгалаа олсон болно. Цаашид сонгуулийн ил тод байдлыг хангах эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох үүднээс олон улсын IDEA байгууллагын гаргасан

“Олон улсын сонгуулийн стандартууд”, “Ардчилсан сонгуулийн сурталчилгааны үйл ажиллагаа”, “Сонгуулийн системийн зохион байгуулалт”, “Сонгуулийг удирдан зохион байгуулах нь” зэрэг ном, товхимлыг орчуулан бодлого боловсруулагчид, улс төрийн намууд болон олон нийтийн хүртээл болголоо. Түүнчлэн сонгуулийн ил тод байдлыг хангахад Монголын иргэний нийгмийн хяналт тавих чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг болох зорилгоор 2007 оны 12-р сард болсон Тайландын парламентын сонгуулийг ажиглах олон улсын багт Монголын иргэний нийгмийн төлөөлөл болгох хоёр хүнийг илгээж туршлага судлууллаа.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

Нээлттэй Нийгэм Форумгаас “Олон Нийтийн Радио Телевизийн тухай” хуулийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “МҮОНТ-ийн шилжилтийн үеийн хөтөлбөрийн бүтэц, мэдээ, нэвтрүүлгийн агуулгын мониторинг” судалгааг хийлгэв. Гурван үе шаттай энэхүү мониторингийг ННФ-ийн захиалгаар Монголын Хэвлэлийн Хүрээлэн нэг жилийн турш хийж гүйцэтгэхээр болсон бөгөөд тайлант хугацаанд эхний хоёр судалгааг хийж гүйцэтгэлээ. Тухайлбал, Олон Нийтийн Телевизийн хөтөлбөрийн бүтэц, мэдээ нэвтрүүлгийн агуулгад хоёр удаа мониторинг хийсний зэрэгцээ

“Олон нийтийн ТВ-ийн талаарх олон нийтийн үнэлэмж”-ийг судалж байна. Мониторингийн эцсийн тайлан 2008 оны нэгдүгээр улиралд бэлэн болж олон нийтэд танилцуулагдах юм. Төслийг хэрэгжүүлэхэд Данийн Аархусын Их сургуулийн профессор Пол Эрик Нилсен, мөн сургуулийн хэвлэл мэдээлэл, олон улсын хөгжлийн судалгааны магистр Деннис Скибстед нар зөвлөгөө өгч байна.

Нээлттэй Нийгэм Форум 2007 онд Лондон дахь Хэвлэл Мэдээллийн Хэрэгслийн Сүлжээ хөтөлбөртэй хамтран Глоб Интернэшнл байгууллагын

“Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчлийн мониторинг ба хараат бус хэвлэл мэдээллийн эрхийг дэмжих нь” төслийг санхүүжүүлж, арга зүйн туслалцаа үзүүлэн ажиллалаа. Монгол дахь үзэл бодлын чөлөөт байдлын илэрхийлэлд мониторинг хийх чадавхийг бэхжүүлэх зорилготой энэхүү төслийн эцсийн тайлан 2008 оны гуравдугаар сард багтан бэлэн болох юм. Төслийн хүрээнд Үзэл Бодлоо Илэрхийлэх Эрх Чөлөөний Олон Улсын Солилцоо (IFEX) болон Москвад төвтэй Хүнд Нөхцөлд буй Сэтгүүлчдийн Төлөө Төв (CJES) байгууллагуудтай хамтран ажиллалаа. Төслийг хэрэгжүүлэх явцад /2006-2007/ үзэл бодлоо илэрхийлэх эрхийн зөрчилд бодитойгоор хяналт шинжилгээ хийж одоогоор 26 зөрчлийг тогтоогоод байна. Түүнчлэн мэргэжлийн хуульчдаар сэтгүүлчдэд зориулсан эрх зүйн зөвлөгөөг тогтмол өгүүлж, сэтгүүлчдийн эсрэг шүүх ажиллагааг ажиглан, үзэл бодлоо илэрхийлэх эрхийн зөрчлийн талаарх мэдээллийг

олон нийтэд түгээж сэтгүүлчдийн дунд судалгаа явуулах юм.

Монголд хараат бус хэвлэл мэдээллийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, сэтгүүлчид мэргэжлийн хувьд өсөн дэвжих боломжийг бүрдүүлэх үүднээс тодорхой сэдвүүдээр сурвалжилга, нийтлэл бичих гарын авлагыг монгол хэлнээ орчуулан олны хүртээл болгов. ННФ-аас зохион явуулдаг төрөл бүрийн хэлэлцүүлэгт сэтгүүлчдийг урин оролцуулж мэдээллээр хангахад хүчин чармайлт тавьж байна.

Түүнчлэн ННФ-ын Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд 2007 онд судлаач Ч.Базар Монголд эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлэхэд сэтгүүлчдийн клуб байгуулах замаар редакцийн хараат бус байдлыг дэмжих, дотоод хяналтын механизмын хэрэгжилтийг сурталчлах, сэтгүүлчдийн мэргэжлийн өсөлтийг дэмжих санал зөвлөмжийг боловсрууллаа.



НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД ТӨСӨВ

Нээлттэй Нийгэм Форум 2007 онд төсвийн мэдээллийг ил тод болгох, төсвийн хэлэлцүүлэгт иргэд, тодорхой ашиг сонирхлын бүлгүүд оролцох боломжоор хангах, мониторинг хийх, бодлогын хэлэлцүүлэг өрнүүлэх зэргээр иргэний нийгмийн чадавхийг бэхжүүлэх зорилт тавин ажиллалаа.

Орон нутгийн түвшинд төсвийн мэдээллийг ил болгох үүднээс Ховд аймгийн болон бүх сумд, сургуулийн төсвийн талаар хялбаршуулсан мэдээллийн самбарыг бэлтгэж иргэд танилцах боломжтой газруудаар байрлууллаа. Төсвийн тоон мэдээллийг иргэдэд ойлгогдохуйц энгийн хэлбэрээр ийнхүү танилцуулсан нь ихээхэн үр дүнтэй болсон бөгөөд цаашид орон нутгийн засаг захиргаатай хамтран хэрэгжүүлэх боломжийг судалж байна.

ННФ өөрийн вэб хуудсаар дамжуулан төсвийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг олон нийтэд танилцуулах ажлаа үргэлжлүүллээ. Үүнд төсвийн

тухай хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээний тойм, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл зэрэг мэдээллийг цуглуулсан болно.

2008 оны улсын нэгдсэн төсвийн төслийг УИХ-аар хэлэлцэх үеэр ННФ төсвийн хэлэлцүүлгийг идэвхжүүлэх зарим ажлыг хийлээ. Тухайлбал, төсвийн төсөлд иж бүрэн үнэлгээ өгөх, төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд шинжилгээ хийх ажлыг мэргэшсэн шинжээчдийн оролцоотой гүйцэтгэв. Мөн УИХ-ын зарим гишүүн, Сангийн яам, судлаач, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөлтэйгээр 2008 оны улсын төсвийн төлөвлөгөөний талаар бодлогын хэлэлцүүлэг явууллаа.

Түүнчлэн Дэлхийн банкнаас хэрэгжүүлж буй “Төсвийн зарцуулалтын тойм” судалгааны хүрээнд орон нутгийн төсөв, төсвийн үйл явц, тогтолцооны талаар тойм бэлтгэж холбогдох байгууллагуудад танилцууллаа. Энэ тоймыг бэлтгэхдээ Архангай, Өмнөговь, Ховд аймгуудад



төсвийн төлөвлөлт, хэрэгжилт, хяналт ямар түвшинд байгааг иж бүрэн үнэлж, тодорхой саналшүүмжийг боловсруулсан болно. Мөн орон нутгийн төсвийн тогтолцоог бэхжүүлэх, төвлөрлийг сааруулах чиглэлээр нөхцөл байдлын үнэлгээ хийж, хөтөлбөр боловсруулах ажлыг Унгар улсад төвтэй Орон Нутгийн Засаг Захиргаа, Төрийн Үйлчилгээний Шинэчлэлийн Санаачилга хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлэв. Тухайлбал, “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хуулинд оруулах өөрчлөлтийн саналуудад дүн шинжилгээ хийн боловсруулсан саналаа УИХ-ын гишүүдэд танилцуулж, санал бодлоо солилцлоо.

ННФ Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар орон нутгийн төсвийн төслийг хэлэлцэх үйл явцыг иргэдэд нээлттэй, тэдний санал бодлыг тусгадаг болгох үүднээс Иргэний Боловсрол төвтэй хамтран ажиллалаа. Уг төвөөс хөдөөгийн гурван суманд ИТХ-аар төсөв хэлэлцэх үеэр иргэдийг оролцуулсан бөгөөд орон нутгийн засаг захиргаа, иргэд нэгдсэн байр сууринд хүрэхэд дэмжлэг үзүүлсэн байна. Уг төслийн үр дүнг цаашид үнэлэн дүгнэх болно.

АНУ-д төвтэй Олон Улсын Төсвийн Төсөл (ОУТТ) байгууллагын хоёр жил тутам явуулдаг Нээлттэй Төсвийн Индекс судалгааны Монгол Улсад хамаарах хэсгийг ННФ хийж гүйцэтгэлээ. Уг судалгааны олон улсын түвшинд нэгтгэсэн дүн 2008 онд гарах хэдий ч Монгол

Улсын авсан оноог өмнөх судалгаатай харьцуулахад тодорхой амжилт гарсан байна. Тухайлбал, Засгийн газраас УИХ-д өргөн барьдаг төсвийн төсөл олон нийтэд бүрэн хэмжээгээрээ хүрсэн нь нийгэмд төсвийн төслийн талаарх хэлэлцүүлгийг өрнүүлэх суурь мэдээлэл болжээ. Хэдийгээр төсвийн явцын гүйцэтгэлийг Сангийн яам тогтмол тайлагнаж байгаа ч гүйцэтгэлийн болон аудитын тайлан тэр бүр иргэдэд ил тод бус, үр дүн нь хангалттай биш байгаа нь харагдлаа.

ННФ-аас 2006 онд зохион байгуулсан “Төрийн ил тод байдал” форумаас төсвийн ил тод байдлын талаар гаргасан санал, зөвлөмжийн хэрэгжилтийг 2007 онд эргэн авч үзлээ. Төсвийн үйл явцыг нээлттэй, иргэдийн оролцоотой болгох чиглэлд зарим нэг ахиц дэвшил гарч буй ч нэн ялангуяа бараа үйлчилгээ худалдан авах үйл явцыг нээлттэй болгон хяналтын механизмыг бүрдүүлэх шаардлагатай хэвээр байна. Төсвийн ил тод байдал форумд оролцогчид энэ асуудлаарх шинэчилсэн санал, зөвлөмжөө хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэлээ.

Төсвийн болон татварын чиглэлээр ажиллах төрийн бус байууллагуудад зориулан Олон Улсын Төсвийн Төсөл байгууллагаас эрхлэн гаргасан хоёр гарын авлагыг монгол хэлнээ орчуулж нийтэллээ. Эдгээр гарын авлагад бусад орны иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааны

шилдэг туршлагыг танилцуулахын хамт төсөв, татварын мэдээлэлд дүн шинжилгээ хийх тодорхой аргуудыг дэлгэрэнгүй тайлбарласан нь Монголын иргэний нийгмийн байгууллагуудад тус дэм болно гэдэгт бид итгэлтэй байна.

Төсвийн хөрөнгийн тодорхой зориулалтын зарцуулалтад мониторинг хийх хэд хэдэн төслийг хэрэгжүүлэхэд нь иргэний нийгмийн зарим байгууллагуудад дэмжлэг үзүүлээ.

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БОЛОН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН МОНИТОРИНГ

Нээлттэй Нийгэм Форумаас төрийн ил тод, хариуцлагатай байдлыг хангахад Төрийн бус байгууллага /ТББ/-уудын хөндлөнгийн хяналт тавих чиг үүргийг нэмэгдүүлэх, тэдний чадавхийг бэхжүүлэх зорилгоор 2005 оноос эхлэн мониторингийн тэтгэлэгт хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлж байгаа билээ. Энэ хугацаанд уг хөтөлбөрт нийт 60 шахам ТББ хамрагдан, мониторинг хийх арга зүйд суралцсан төдийгүй төрийн үйлчилгээ, бодлогын хэрэгжилт, донорын зээл тусламж зэрэг салбар чиглэлээр богино хугацааны мониторингийн төсөл хэрэгжүүлэн практик туршлага олж авчээ.

1990-ээд оноос эхлэн саяхныг хүртэл ТББ-ын үйл ажиллагааны чиглэл, нийгмийн өмнө хүлээсэн үүрэг нь үйлчилгээ үзүүлэх, соён гэгээрүүлэх тал дээр голлож, иргэний нийгмийн гүйцэтгэвэл зохих үндсэн үүрэг болох төр, засгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих асуудал харьцангуй сул

байсан юм. Мониторингийн тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжсэн сүүлийн жилүүдэд энэ байдалд дорвитой өөрчлөлт орж, хүний эрх, уул уурхай, байгаль орчин, нийгмийн халамж, төсөв, боловсрол зэрэг салбар чиглэлд төрийн явуулж буй бодлого, хэрэгжилт, иргэдэд үзүүлж буй үйлчилгээнд хяналт тавих ТББ-уудын тоо илт нэмэгдлээ.

Нөгөөтэйгүүр, төрийн байгууллагуудын зүгээс ТББ-ын гүйцэтгэж буй хөндлөнгийн хяналтын ач холбогдлыг үнэлэн хүлээн зөвшөөрөх хандлага ажиглагдаж байгаа нь тун чухал үр дүн юм. Хэдийгээр цөөн боловч бусдад үлгэр жишээ болохуйц зарим нэг үр дүнг дурдвал, 2007 онд Авилгатай Тэмцэх Газрын албан ёсны хүсэлтээр тус газраас төрийн байгууллагуудад хандан гаргасан ил тод байдлыг хангахад чиглэсэн 18 зүйл бүхий зөвлөмжийн хэрэгжилтэд Глоб Интернэшнл ТББ манай Форумын санхүүжилтээр мониторинг хийсэн юм. Мониторингийн явцад уг зөвлөмж

төрийн байгууллагуудад нэлээд сул хэрэгжиж буйг тогтоон нийтэд мэдээлж АТГ-аас ажлын хэсэг гарган тодорхой арга хэмжээ авсан нь үр дүнтэй ажил болов.

2007 онд ННФ-ын мониторингийн тэтгэлэгт хөтөлбөрт хот болон хөдөө орон нутгийн нийт 21 байгууллага шалгаран төрийн үйлчилгээ, бодлогын хэрэгжилтийн мониторингийн төслийг хэрэгжүүлж, илэрсэн зөрчил дутагдлыг засч залруулахад чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа явуулж байна. 2007 онд хэрэгжсэн төслүүд нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгай дансны үйлчилгээ, орон нутгийн төсвийн төлөвлөлт ба гүйцэтгэлийн үйл явц, төрийн албанд ажилтан сонгон шалгаруулах үйл ажиллагаа, сургуулийн сурах бичгийн хүртээмж, сурагчдаас авч буй хууль бус төлбөр хураамж, “Улс төрийн намын тухай” хуулийн санхүүжилтийн талаарх заалтуудын хэрэгжилт, “Архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийн хэрэгжилт, шатахуун түгээх станц эрхлэх зөвшөөрөл олгох төрийн үйлчилгээ, Хөдөлмөрийн хуулийн 111-р зүйлийн хэрэгжилт, орон нутгийн олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагаа, Улаанбаатар хотын нийтийн эзэмшлийн газар олголт,

“Нийгмийн халамжийн тухай” хуулийн хэрэгжилт, Авилгын эсрэг хуулийн зарим заалтын хэрэгжилт, нийгмийн халамжийн үйлчилгээ зэрэг асуудлаар мониторинг хийлээ.

Хөтөлбөрийн хүрээнд ННФ-ын зүгээс уламжлал ёсоор оролцогч ТББ-уудад мониторингийн арга зүйн талаар цуврал сургалт зохион байгуулж, төсөл хэрэгжүүлэх явцад нь байнга зөвлөгөө туслалцаа үзүүлсэн болно. Түүнчлэн ТББ-уудын туршлага солилцох, хамтран ажиллах бололцоог дэмжихийн сацуу нөлөөллийн үйл ажиллагаанд нь нэмэлт дэмжлэг үзүүлж тайланг хэвлэн нийтийн хүртээл болгосон байна.

Цаашид уг хөтөлбөрт хөдөө орон нутгаас оролцох ТББ-уудын тоог нэмэгдүүлэхэд анхаарч буй бөгөөд 2007 онд Дархан, Завхан, Баянхонгор аймгуудад 100 орчим ТББ-уудын төлөөллийг оролцуулан мониторингийн төсөл хэрхэн бичих тухай семинарыг зохион байгууллаа. Түүнчлэн алслагдсан хөдөө орон нутгийн 40 шахам байгууллагын төлөөллийг Улаанбаатарт урин мониторингийн арга зүйн талаар хоёр өдрийн сургалт зохион байгуулсан нь үр дүнтэй боллоо.

ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГА

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС)-ыг Монгол Улсад хэрэгжүүлэх ажлыг хөхиүлэн дэмжихэд урьдын адил ихээхэн хүчин чармайлт гарган Нээлттэй Нийгэм Форумын төлөөлөл ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсэгт багтдаг бөгөөд үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцож ирлээ. Тухайлбал, ОУИТБС-ын тайлагнах маягтуудыг эцэслэн боловсруулахад тодорхой саналууд боловсруулан дийлэнх хувийг нь маягтын эцсийн хувилбарт тусгуулж чадсан төдийгүй ОУИТБС-ын анхны тайланг гаргах үүрэгтэй олон улсын аудиторыг сонгох ажлын хэсэгт орж ажиллалаа.

Уул уурхай, газрын тосны компаниудын талаарх мэдээллийг олон нийтэд ил болгох чиглэлээр “Ил Тод Байдал” санд санхүүгийн дэмжлэг үзүүллээ. Уг сангийн гүйцэтгэсэн төслийн хүрээнд компаниудын ил тод байдлын чансааг тогтоон жагсааж, компаниуд, иргэний нийгэм болон төр, засгийн байгууллагуудын дунд хэлэлцүүлэг өрнүүллээ. Компаниудын улсад төлсөн бүх төрлийн татвар, төлбөр, хураамжийн талаарх мэдээллийг ил тод болгосон нь тухайн салбарын бодит үр өгөөжийг иргэд үнэлэн цэгнэхэд нэлээд тус дөхөм болсон юм. Монгол Улсад уул уурхайн чиглэлээр хайгуулийн болон ашиглалтын

үйл ажиллагаа эрхлэхээр олгогдсон бүх лицензийн дэлгэрэнгүй мэдээллийг олон нийтэд анх удаа хүргэсэн нь төслийн бас нэг чухал үр дүн байлаа.

“Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөрийн хэмжээг дараа оны нэгдүгээр улиралд багтаан нийтэд мэдээлнэ” гэсэн Ашигт малтмалын тухай хуулийн 48.10 дугаар заалтыг биелүүлэхийг ННФ компаниудад уриалж хэрэгжилтэд нь мониторинг хийлээ. Хуулийн уг заалтыг хугацаанд нь биелүүлсэн ганцхан компани гарсан нь анхаарал татаж байв. Мониторингийн үр дүнг олон нийтэд танилцуулсан уулзалт зохион байгуулж хэлэлцүүлэг өрнүүллээ.

Олборлох салбарын ил тод байдлын төлөө “Төлсөн Авснаа Нийтэл” эвслийн үйл ажиллагаанд ННФ идэвхтэй оролцож, санхүүгийн болон арга зүйн дэмжлэг үзүүлсэн болно. Эвсэлтэй хамтран уул уурхайн томоохон бүс нутаг болох Дорнод, Өмнөговь, Сүхбаатар, Баянхонгор аймгуудад ОУИТБС-ыг сурталчлах, компани, орон нутгийн захиргаа, иргэдийн оролцоотой нээлттэй хэлэлцүүлгийг өрнүүлэх зорилгоор цуврал уулзалт

зохион байгууллаа. Эдгээр уулзалтын үр дүнд орон нутгийн түвшинд ОУИТБС-ын талаар тодорхой мэдлэг, ойлголттой болсон төдийгүй Монгол Улсын ОУИТБС-ын анхны тайлан гарахаас хавьгүй өмнө тодорхой компаниуд улсад төлсөн татваруудаа нээлттэй зарлаж эхэлсэн нь томоохон амжилт болсон юм. Түүнчлэн орон нутгийн хөгжилд уул уурхайн салбарын оруулах хувь нэмэр, байгаль орчны нөхөн сэргээлтийн асуудлаар ч оролцогчид байр сууриа илэрхийлж, цаашид авах шаардлагатай арга хэмжээний талаар ярилцаж байв. Энэ хүрээнд эвслийн байгууллагууд болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн төлөөлөгчид хэд хэдэн уурхайг үзэх боломжоор хангагдсан юм. Тухайлбал, Цайрт минералз, Вэстэрн Проспектор, Цав, Тамсаг, Хан ресорсес, Шинь Шинь, Оюу Толгой, Таван Толгой зэрэг компани, уурхайн үйл ажиллагаатай газар дээр нь танилцсаны зэрэгцээ төвийн телевизээр мэдээ, баримтат кино бэлтгэж нэвтрүүлж, өдөр тутмын сонины цуврал нийтлэл гаргав.

Архангай, Өвөрхангай аймгийн зарим суманд Хүний Эрх - Хөгжил Төв болон Ариун Суварга хөдөлгөөнтэй хамтран ОУИТБС болон Ашигт малтмалын тухай хуулийн талаар сургалт зохион байгуулж, цаашид ийм сургалтыг бусад уул уурхайн бүсүүдэд зохион байгуулах зорилготой санхүүжилтийг Хүний Эрх - Хөгжил төвд олгон дэмжлэг үзүүлээ.

Олборлох салбарын ил тод байдлын талаар иргэний нийгмийн форумыг зохион байгууллаа. Уг форумын зорилго нь 2006 онд зохиогдсон “Төрийн ил тод байдал” үндэсний форумаас салбарын ил тод байдалтай холбоотой гарсан санал зөвлөмжийн хэрэгжилтэд үнэлгээ дүгнэлт өгч, цаашид анхаарах зүйлсийг тодорхойлох явдал байв. Форумоор ОУИТБС, лиценз, гэрээ хэлэлцээрийн ил тод байдалд иргэний нийгмийн байр сууринаас үнэлэлт өглөө.

Лиценз олголтын үйл ажиллагаанд хөндлөнгийн мониторинг хийх төслийг Хүний Эрх -Хөгжил Төвтэй хамтран 2007 онд эхлүүлж, хайгуулийн болон ашиглалтын тусгай зөвшөөрөл шинээр олгох үйл явц хуулийн дагуу, нээлттэй, ил тод, шударга явагдаж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж байна.

Дэлхийн банкны Хөгжлийн тэтгэлгийн сангаас 2006 онд тэтгэлэг авсан төрийн бус байгууллагууд төслөө хэрэгжүүлж дууслаа. Тухайлбал, Эрхүү хотын Улс Ардын Аж Ахуйн Дээд Сургууль төгсөгчдийн Монголын холбоо “Олборлох салбарын орлогын хуваарилалт” хэмээх судалгааг, Онон-Улз гол хөдөлгөөн, Зориг сан, Сэлэнгэ аймгийн Өглөө Таймс сонин, Уугуул хөдөлгөөн зэрэг байгууллагууд ОУИТБС-ыг үндэсний болон орон нутгийн түвшинд сурталчлах ажлыг гүйцэтгэж, Миний Монголын Газар

Шороо хөдөлгөөнийхөн уг санаачилгын хэрэгжилтийг түргэтгэх нөлөөллийн үйл ажиллагаа явуулав. Төслийн тайланг дээрх байгууллагууд олон нийтэд танилцуулж үр дүнгээр нь хэлэлцүүлэг өрнүүлсэн болно.

ОУИТБС-ыг дэмждэг Төв Ази, Кавказын бүсийн иргэний нийгмийн байгууллагуудын олон улсын бага хурлыг Монголд зохион байгуулав. Азербайжан, Гүрж, Казахстан, Киргиз, Орос зэрэг улс оронд уг санаачилга хэрхэн хэрэгжиж буйд үнэлгээ өгч, мэдээлэл туршлага солилцон цаашид хамтран ажиллах чиглэл, хэлбэрүүдийн талаар ярилцлаа. Түүнчлэн төлөөлөгчид Бороогийн алтны уурхайн үйл ажиллагаатай танилцав.

Монголын иргэний нийгмийн байгууллага, төлөөлөгчдийг гадаад арга хэмжээнд оролцож бусад улс орны ижил төстэй байгууллагуудтай туршлага солилцох боломж нөхцлөөр хангахад ННФ анхаарал тавьж ажиллалаа.

Азербайжан улсад зохион байгуулагдсан “Олборлох салбарын орлогын үр нөлөөг хянах нь” сэдэвт бага хурал, Казахстан улсад болсон бүсийн иргэний нийгмийн байгууллагуудын сүлжээний бага хурал, Хариуцлагатай Уул Уурхайн Санаачилгаас зохион байгуулсан Өвөр Монголын уул уурхайн үйл ажиллагаатай танилцах аялалд “Төлсөн Авснаа Нийтэл” эвслийн төлөөлөгчдийг оролцуулснаас гадна ОУИТБС амжилттай хэрэгжиж буй, уул уурхайн салбарын арвин туршлагатай Гана улсын иргэний нийгмийн байгууллагууд, уул уурхайн үйл ажиллагаа явагддаг газрын иргэдтэй уулзаж танилцах аяллыг амжилттай зохион байгууллаа. “Төлснөө Нийтэл” олон улсын кампанит ажлын Стратегийн зөвлөх бүлэгт тухайн бүс нутгаа төлөөлөн оролцож байна. Энэ бүх үйл ажиллагааны үр дүнд бусад улс орны туршлага судлах, санал, мэдээлэл солилцох, Монголын тухай ойлголт өгөх таатай боломж бүрдлээ.

ИРГЭДИЙН ОРОЛЦОО БА МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

Нээлттэй Нийгэм Форум байгуулагдсан цагаасаа эхлэн мэдээллийн эрх чөлөөг хангах асуудлыг бодлогын түвшинд дэвшүүлэн тавихад ихээхэн анхаарч ирсэн юм. 2007 онд мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн хоёр дахь төслийг боловсруулах УИХ-ын ажлын хэсэгтэй хамтран ажиллалаа. Хуулийн төслийг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэх тал дээр мэргэжлийн санал зөвлөмж боловсруулсны зэрэгцээ бусад улс орны туршлага судлах ажлыг дэс дараатай зохион байгуулав. Засгийн Газар Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг хэлэлцээд хоёр удаа буцаасан агаад хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр байхгүй, мэдээллийн аюулгүй байдлын асуудалтай багцлан авч үзэх шаардлагатай хэмээн тайлбарлаж буй хэдий ч үнэн хэрэгтээ төрийн мэдэлд байгаа мэдээллийг нээлттэй болгох улстөрийн хүсэл зориг дутмаг байгаатай энэ нь холбоотой юм. ННФ-аас Глоб Интернэйшнл байгууллагатай хамтран зохион байгуулсан дугуй ширээний ярилцлагын үр дүнд Ц.Мөнх-Оргил тэргүүтэй УИХ-ын гишүүдийн санаачилгаар энэ хуулийн төслийг УИХ-д өргөн бариад байна. Энэ асуудлаар ННФ цуврал хэлэлцүүлэг зохион байгуулж иргэний нийгмийн байр суурь, санал зөвлөмжийг боловсруулан



хууль санаачлагчдад хүргэлээ. Түүнчлэн, хуулийн төслийг олон нийтэд хүргэх үүднээс УИХ-ын болон Форумын портал сайтад байрлуулсан бөгөөд хуулийн төсөлд зориулан санал зөвлөмж боловсруулан ажлын хэсгийн гишүүдэд хүргэсэн болно.

Байгууллагын нууцын тухай хуулийг хүчингүй болгон Төрийн нууцын тухай хуулийг шинэчлэхгүйгээр мэдээллийн эрх чөлөөний асуудлаар ахиц дэвшил гарахгүй гэсэн байр суурийг иргэний

нийгэм хүчтэй илэрхийлсний үр дүнд УИХ-ын Хууль Зүйн Байнгын Хороо асуудлыг нааштай авч үзэх болсон байна.

ННФ хууль боловсруулах, батлах үйл явцын ил тод байдлыг хангах, иргэдийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдсэн хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор гадаадын дэвшилтэт туршлагаас суралцах, санаа авах боломжийг бүрдүүлэх, өөрийн нөхцөл байдалд тохирсон загварыг олж сонгоход дэмжлэг үзүүлэх санаачилгыг хэрэгжүүллээ. Энэхүү санаачилгыг Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн Дорно Дорно - Хил Хязгааргүй Түншлэл бүсийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлсэн бөгөөд 2007 онд бодлого боловсруулагчид, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулан Герман улсын Парламентын иргэдтэй харилцах чиг үүрэг бүхий байнгын хорооны үйл ажиллагаатай танилцах аяллыг зохион байгууллаа.

Эдгээр арга хэмжээний үр дүнд хуулийн төсөл боловсруулах, хэлэлцэж батлах шатанд ил тод байдлыг хангах, иргэдийн оролцоог бодитой болгох

үүднээс хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг УИХ-ын гишүүн Б.Мөнхтуяагаар ахлуулан байгуулсан байна. Ажлын хэсэг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг боловсруулан УИХ-д өргөн барьсан бөгөөд эдүгээ хэлэлцэгдэхээр хүлээгдэж байна. Хуулийн төслийг боловсруулах явцад ННФ-аас хэлэлцүүлэг өрнүүлж олон нийтийн санал бодлыг тусгах ажлыг зохион байгууллаа. Энэхүү хуулийн төсөл нь хууль боловсруулах явц дахь ил тод байдлыг хангахад чиглэгдсэн анхны эрх зүйн зохицуулалт болох юм.

ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА

Монголын хүн амын дунд ядуу иргэдийн эзлэх хувь өндөр, тэдгээр хүмүүс гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд өмгөөлөгч авах боломж хомс байгаа тул төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх нь хүний эрхийг хангахад чухал үүрэгтэй юм. Хуулийн хэрэгжилт, туслалцаа үзүүлэх ажлын уялдаа сул, санхүүжилт хомс зэрэг олон шалтгаанаас үүдэн төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх нь тулгамдсан асуудал болж байна.

Нээлттэй Нийгэм Форум өмнөх он жилүүдэд төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрийг боловсруулахад дэмжлэг үзүүлэн Хууль зүй, Дотоод Хэргийн Яам /ХЗДХЯ/ болон Будапештэд төвтэй “Нээлттэй Нийгмийн Эрхзүйн Санаачилга” байгууллагатай хамтран “Төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх эрх зүйн туслалцаа” төслийг хэрэгжүүлсэн бөгөөд 2007 онд энэ ажлын шууд үр дүн болох Улаанбаатарын Сонгинохайрхан дүүрэг болон Хэнтий аймаг дахь төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн туслалцаа үзүүлэх туршилтын төвүүдийг ХЗДХЯ-нд хүлээлгэн өглөө. Эдгээр туршилтын үр дүнд шинээр байгуулагдах төвүүдийн дагаж мөрдөх үйл ажиллагааны загвар журам болон цагдаагийн байгууллагатай ажиллах стандартыг боловсруулсан байна.

Төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн туслалцаа үзүүлэх үндэсний

тогтолцооны шинэчлэлийн хүрээнд энэ асуудлыг хариуцсан Үндэсний Зөвлөл байгуулагдлаа. Энэхүү зөвлөл нь ХЗДХЯ дээр ажлын албатай байх ба төрийн болон ТББ-уудын төлөөллөөс бүрдэх юм. Түүнчлэн Эрх зүйн туслалцааны төвүүд байгуулагдах бэлтгэл хангагдаж байна. Энэхүү үйл ажиллагаанд НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр хамтран ажиллаж техник, санхүүгийн туслалцаа үзүүлж байна.

ННФ ХЗДХЯ-тай хамтран орон нутагт эрх зүйн боловсрол, мэдээлэл, зөвлөгөө лавлагааны тогтолцоог боловсронгуй болгох үүднээс “Эрх зүйн мэдээлэл, үйлчилгээг орон нутагт нэвтрүүлэх нь” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, иргэдэд эрх зүйн мэдээлэл, зөвлөгөө өгөх сургалт зохион байгууллаа. Энэхүү төслийн үр дүнд иргэдэд эрх зүйн мэдээлэл хүргэх үйлчилгээ орон нутгийн засаг захиргаанд институцчилагдан, ХЗДХЯ-наас аргачлал, стандартаар хангах үйл ажиллагаа хэвшиж байна. Төслийн хүрээнд “Иргэдийн эрх зүйн хөтөч” номыг хэвлүүлэхэд зориулж ХЗДХЯ-нд санхүүгийн дэмжлэг үзүүллээ. Энэ ном нь иргэд ажил хөдөлмөр эрхлэх, гэр бүл болох, худалдаа хийх, тэтгэвэр тэтгэмж авах, захиргааны байгууллагуудтай хэрхэн харилцах, маргаантай асуудлаа зохицуулах зэрэг өдөр тутмын амьдралд байнга оролцож байдаг харилцааны эрх зүйн зохицуулалтын асуудлыг цогцоор нь багтаасан анхны томоохон хэмжээний сурах бичиг болсон байна.

СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛӨЛ

Дэлхийдахинаа өргөн хэрэглэгддэг хэдий ч манай улсын хувьд шинэ эл ойлголтыг Монголд нэвтрүүлэхэд дэмжлэг болгох үүднээс Монгол дахь стратегийн өмгөөллийн анхны оролдлого, туршлагад тулгуурлан ийм өмгөөллийг хэрхэн хийх арга зүйг эзэмшүүлэхэд зориулсан цуврал сургалтыг ТББ-ууд болон өмгөөлөгчдийн дунд зохион явууллаа. Сургалт нь байгаль орчныг хамгаалах, мэдээллийн эрх чөлөөг хангах чиглэлд түлхүү анхаарсан бөгөөд 60 гаруй ТББ-ын төлөөлөгчид, хуульч өмгөөлөгчид оролцов. Сургалтуудыг АНУ-д төвтэй Глобал Райтс, Нийтийн Эрх ашгийн Эрх зүйн Хүрээлэн зэрэг байгууллагатай хамтран явуулж, АНУ-ын болон Ази, зүүн европын орнуудын дээрх чиглэлээр ажилладаг ТББ-уудын туршлагатай өмгөөлөгч хуульчид хөтлөн явууллаа.

Стратегийн өмгөөллийн жишиг загварыг бий болгох зорилгоор Хүний Эрх - Хөгжил төвд тэтгэлэг олгосноор уул уурхайн бүсэд оршин суугаа иргэдийн нийтлэг эрх ашгийг хамгаалахад холбогдох хуулийн заалтуудыг хэрэглэх

практикийг бий болгох, ялангуяа нийтийн эрх ашгаа шүүхээр хамгаалах талаар иргэдийн мэдлэг мэдээллийг дээшлүүлэхэд ихээхэн тустай болсон гэж үзэж байна. Төслийн хүрээнд байгаль орчны асуудалд холбогдох 10 хэргийг сонгон шүүхэд нэхэмжлэл гаргаж, стратегийн өмгөөлөл явуулах хуульчдын багийг ажиллуулах идэвхи санаачилгыг өрнүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэлэлцүүлэх зэрэг үйл ажиллагааг явууллаа. Түүнчлэн орон нутгийн ТББ болох Хөвсгөл Далайн Эзэд хөдөлгөөнд байгаль орчны бохирдлын эсрэг стратегийн өмгөөллийг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлсэн байна.

Эдгээр арга хэмжээний үр дүнд нийтийн эрх ашгийг хамгаалах үр нөлөөтэй арга хэрэгсэл болох стратегийн өмгөөллийг иргэний нийгмийн байгууллагуудад танилцуулсан төдийгүй энэ чиглэлд тодорхой мэдлэг, туршлага хуримтлагдаж эхэлсэн нь чухал ач холбогдолтой болсон юм.

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Төрийн бус байгууллагын эрх зүйн орчинг боловсронгуй болгох асуудлыг Нээлттэй Нийгэм Форум 2003 оноос эхлэн анхаарч ирлээ. Хуулийн төслийг боловсруулах хоёр талын оролцоотой ажлын хэсгийн үйл ажиллагааг чиглүүлж, ТББ-ын зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэх, техникийн туслалцаа үзүүлэх, хамгийн гол нь энэ үйл явцын ил тод байдлыг хангах, ялангуяа хуулийн төсөл боловсруулахад ТББ-уудын санал бодлыг тусгахад Форумын зүгээс түлхүү анхаарсан болно

ТББ-ын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаарх олон улсын туршлага болон иргэний нийгмийн байгууллагуудын байр суурийг нэгтгэсэн судалгаа, мэдээллийн баазыг бүрдүүллээ. ТББ-ууд дотоод засаглалаа бэхжүүлж, ил тод хариуцлагатай байдлыг хангах тухай мэдлэг мэдээлэл нэмэгдэв. ТББ-ын дотоод засаглалын ойлголтыг

улам бэхжүүлэх, практикт нэвтрүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор гарын авлага орчуулан ТББ-уудад хүргэлээ. Улмаар ТББ-уудад зориулсан сургалтыг зохион байгуулахаар төлөвлөж байна.

ННФ нь ТББ-уудын лавлахыг шинэчилж веб сайт дээр байрлуулаад байна. Тодорхой хугацаанд туршиж нэмэлт тодотгол хийсний үндсэн дээр хэвлэн нийтийн хүртээл болгох юм. Энэ лавлахыг ННФ 2002 онд гаргаж байсан бөгөөд түүнээс хойш маш олон ТББ шинээр байгуулагдсан төдийгүй ихэнх нь үйл ажиллагааны чиглэл, удирдлагын бүтэц, хаягийн хувьд өөрчлөгджээ. Энэхүү төслийг ХЗДХЯ-тай хамтран хэрэгжүүлж буй бөгөөд тус яамны ТББ-ын бүртгэлийн шинэчилсэн мэдээллийг цахим баазад оруулан тогтмол баяжуулах юм. ТББ-ын лавлах номонд ТББ-уудыг зорилго, үйл ажиллагааны чиглэлээр нь ангилсан болно.

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ИНДЕКС

Нээлттэй Нийгэм Форум 2005 оноос эхлэн төрийн бодлого, институциуд хувь хүний арилжаа солилцоо, бизнесийн өрсөлдөөнд оролцох эрх чөлөөг хэрхэн хангаж, хувийн өмчийг хамгаалж чадаж байгаа эсэхийг судалдаг эдийн засгийн эрх чөлөөний асуудалд анхаарлаа хандуулан тодорхой үйл ажиллагаа явууллаа. Энэ хүрээнд ННФ дэлхий дахинаа эдийн засгийн эрх чөлөөг хэмждэг томоохон судалгааны институт болох Фрейзер институттэй түншлэн ажиллаж тоон мэдээллээр хангах, манай улсын талаарх тооцоолсон индексийг шалгах ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Монгол дахь эдийн засгийн эрх чөлөөг хэмжих чадавхийг бэхжүүлэхийг дэмжих, эдийн засгийн эрх чөлөөний гол асуудлуудад бодлого боловсруулагчид, олон нийтийн анхаарлыг хандуулах зорилгоор Монгол Улсын Их Сургуулийн Эдийн Засгийн Сургуультай хамтран “Монголын эдийн засгийн эрх чөлөөний жилийн тойм”-ыг тухайн жилд тулгарч байгаа эдийн засгийн шийдвэрлэх асуудлаар боловсруулж гаргаж байна.

“Монголын эдийн засгийн эрх чөлөөний

жилийн тойм-2007”-д “Монгол Улсын өрсөлдөөний өнөөгийн байдал, түүний үр нөлөө, цаашдын төлөв”-ийн асуудлыг зарим гол салбараар төлөөлүүлэн судалж бодлогын зөвлөмж боловсруулсан юм. Сүүлийн жилүүдэд Монголд зарим салбарын өрсөлдөөн шударга бус, бараа, бүтээгдэхүүний үнэ зохиомлоор хэт өндөр түвшинд хадгалагдах, үнэ шалтгаангүй өсөх, тендерт хамгийн өндөр чанартай, хямд үнэтэй нийлүүлэгч бус, танил тал, авилга, эсвэл нууц тохиролцооны аргаар илүү өндөр үнэтэй, муу чанартай бараа бүтээгдэхүүн нийлүүлэгдэх зэрэг гажуудал үүсч, улмаар бизнес эрхлэгчид болон хэрэглэгчид ихээр хохирох болжээ. Иймд шударга бус өрсөлдөөнтэй тэмцэх, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хуулийн хэрэгжилтийг сайжруулах асуудал хурцаар тавигдаж буй үед уг судалгааг хийсэн нь цаг үеэ олсон ажил боллоо. Уламжлал ёсоор жилийн тоймын үр дүн, санал зөвлөмжийг бодлого боловсруулагчид, эдийн засагчид, компаниуд, Засгийн газрын холбогдох албан тушаалтнууд, судлаачдад

танилцуулан хэлэлцүүлж тэдний санаа бодол, санал шүүмжийг тоймын эцсийн хувилбарт тусгалаа. Энэ төрлийн уулзалт ярилцлага болон судалгааны хэвлэмэл хувилбар нь эдийн засгийн эрх чөлөөнд тулгарч буй хүндрэл бэрхшээл, гол асуудлуудад олон нийтийн анхаарлыг хандуулахад тус дөхөм болж буй бөгөөд цаашдаа Монголын эдийн засгийн бодлогын талаар илүү өргөн хүрээтэй мэтгэлцээн өрнөхөд хүргэнэ гэж ННФ үзэж байна.

Түүнчлэн эдийн засаг, бизнесийн үндсэн ойлголт, зарчим, эдийн засгийн эрх чөлөөний талаарх мэдлэгийг энгийн, ойлгомжтой илэрхийлсэн “Эдийн засаг энгийнээр” хэмээх номыг англи хэлнээс хөрвүүлэн хэвлүүлсэн нь иргэдийн мэдлэг, мэдээлэлд томоохон хөрөнгө оруулалт болсон гэдэгт найдаж байна. Номын хэлэлцүүлгийг эдийн засагчид, бодлого боловсруулагчид болон уншигчдын дунд зохион байгууллаа.

Тоймын зарим хэсгээс:

Монголын зарим зах зээлийн төвлөрөл, өрсөлдөөн, үнийн байдал

Үйл ажиллагааны ангилал	Херфиндал-Хершманы индекс	Зах зээлийн төвлөрөл	Зах зээлийн өрсөлдөөн	Үнэ
Газрын тосны импорт	0.227	өндөр	Илт давамгай байдалтай аж ахуйн нэгжүүд ноёрхсон, картелийн шинж чанарыг агуулсан зах зээл. Нэвтрэн ороход хэцүү, нийлүүлэлт нь ганцхан импортын нэг эх үүсвэрээс хамааралтай. Өрсөлдөөнгүй гэж үзэж болно.	Сүүлийн жилүүдэд эрчимтэй өссөн
Утас хөдөлгөөнт холбоо	0.616	Мобиком илт давамгай	Өрсөлдөөнтэй, олигополийн үнийн (Бертрандын) өрсөлдөөний шинж чанарыг агуулсан. Шинэ компаниуд байнга орж ирдэг.	Сүүлийн жилүүдэд эрчимтэй буурсан
Мах, махан бүтээгдэхүүн	0.070	Төвлөрлийн хувь нь доогуур боловч зах зээлийн үйл ажиллагаа нь шударга бус өрсөлдөөний шинж чанартай	Өрсөлдөөн хязгаарлагдмал, бөөний худалдааны биржүүд хөгжөөгүй учир үр ашиг муутай.	Сүүлийн жилүүдэд эрчимтэй өссөн
Ноос, ноолуур	0.115	Дунд зэрэг	Өрсөлдөөн хязгаарлагдмал, бөөний худалдааны биржүүд хөгжөөгүй учир үр ашиг муутай, дамалсан худалдааны шинжтэй	Төдийлөн өөрчлөгдөөгүй
Нийтийн тээвэр	Автобус- 0.230 Такси - 0.150	Дунд зэрэг	Дунд зэргийн өрсөлдөөнтэй, зохицуулалт ихтэй	Өсч байгаа

Бодлогын зөвлөмжийн хэсгээс:

Салбаруудын өрсөлдөөн

- Газар болон уур уурхайн салбарт лиценз, зөвшөөрлийн олголт аль болохоор шударга өрсөлдөөний зарчимд тулгуурласан байдлаар зохион байгуулагдаж, эрэлтээс үүсч байгаа ашиг төрийн болон орон нутгийн төсвийн эх үүсвэр болох талд анхаарах хэрэгтэй. Иймээс газрын болон уул уурхайн лицензийн олголтыг нээлттэй, уралдаант байдлаар зохион байгуулах, газар олголтыг дүүргүүдийн мэдлээс гарган нэгдсэн газрын худалдаа, биржийг зохион байгуулах нь зүйтэй. Уул уурхайн салбарт лиценз олголтыг замбараатай, шалгууртай болгож, хүссэн хүн болгонд олгох бус, хөрөнгө оруулалт хийх, олборлолт явуулах чадвартай компаниудад өрсөлдөөнт замаар олгох үндсэн дээр лицензийн дамлан худалдах явдлыг зогсоох, лицензийн ченжүүдийн үйл ажиллагаанд саад тавих шаардлагатай.
- Газрын тос, мах, ноос, сүүний салбарт биржүүдийг байгуулах үйл ажиллагааг сонгодог хэлбэрт оруулах, үр өгөөжтэй зах зээлийг бий болгох шаардлагатай. Энэ салбарт цөөн тооны давамгайл байдалтай компаниуд, ченжүүдийн үйл ажиллагааг хязгаарлахын тулд бусад компани аж ахуйн нэгжүүд чөлөөтэй нэвтрэн орох боломжийг бүрдүүлж өгөх шаардлагатай.
- Нийтийн тээврийн салбарт өрсөлдөөнийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ зорчигчдын эрх ашгийг хамгаалах бодлого чухал байна. Өрсөлдөөнийг хөгжүүлэхийн тулд тус салбарт шинэ операторуудыг оруулах, үйлчилгээний нийлүүлэлтийг өсгөх хэрэгтэй.
- Цахилгаан, дулаан үйлдвэрлэл, эцсийн үйлчилгээг үзүүлэх шатанд компаниуд чөлөөтэй өрсөлдөх, эцэст нь илүү чанартай бөгөөд хямд бүтээгдэхүүн бий болгохыг эрмэлзэх ёстой. Иймд дэд бүтцийн шинэтгэл хийх хэрэгтэй.

МОНГОЛ УЛСЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАР

Шилжилтийн эдийн засаг бүхий, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн багатай орнуудын дотроос Монгол Улс нь чөлөөт зах зээлийн эдийн засгийн үндэс суурийг тавих талаараа багагүй ахиц дэвшил гаргаж байгаа юм. Ардчилсан шилжилтийн үе дуусах шатандаа орсон энэ үед манай улс өрсөлдөх чадвараа хөгжүүлэхэд онцгой анхаарах шаардлагатай байна.

АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагаас санхүүжүүлдэг Эдийн Засгийн Бодлогын Шинэчлэл, Өрсөлдөх Чадвар төслийн хүрээнд Дэлхийн Эдийн Засгийн Форумын /ДЭЗФ/ эдийн засгийн өрсөлдөх чадвар, өсөлтөд нөлөөлөх хүчин зүйлсийг улс орнуудын түвшинд харьцуулсан судалгаанд Монгол Улсыг хамруулах ажлыг 2005 онд анх эхэлсэн бөгөөд ДЭЗФ-ын үндэсний түншлэгч байгууллагын үүргийг ННФ гүйцэтгэж байгаа юм. Энэ хүрээнд Форумас дэлхий дахины болон Монгол Улсын өрсөлдөх чадварын асуудлаар бизнесийнхэн болон засгийн газрын төлөөллийг оролцуулан цуврал уулзалт ярилцлага хийж байна. ННФ Хүман Фортис Консалтанси компанитай хамтран жил бүр “Бизнесийн удирдах ажилтнуудын санаа бодол”-ын судалгааг хийж буй бөгөөд 2007 оны судалгаанд Монголд үйл ажиллагаагаа явуулж буй 90 гаруй компани оролцлоо.

Удирдах ажилтны санаа бодлын судалгаа буюу “Бизнесийн салбарынхны дуу хоолой” нь Дэлхий дахины өрсөлдөх чадвар тайлангийн нэг чухал хэсэг юм. Энэ жилийн судалгаанд нийт 131 улсаас Монгол улс 101 дүгээр байрт бичигдсэн нь өмнөх жилийнхтэй /96 дугаар байр/ харьцуулахад нэлээн ухарсан үзүүлэлт юм. Манай хөрш хоёр орон болох Хятад, Орос улс нь Монголоос тун дээгүүр буюу 14, 58 дугаар байрыг тус тус эзэлсэн байна.

“Дэлхий дахины өрсөлдөх чадварын тайлан 2007-2008”-д танилцуулснаар Монголын тэргүүлэх бизнесийн удирдлагууд “бизнес эрхлэхэд хамгийн бэрхшээлтэй хүчин зүйлс”-д төр засгийн хүнд суртал, авилга, татварын зохицуулалт, ажиллах хүчний боловсрол, Засгийн газрын тогтворгүй байдал, санхүүжилт олж авах боломж зэргийг нэрлэжээ.

Энэ сэдвийн хүрээнд ННФ Монгол Улсын Үйлдвэр, Худалдааны Яамтай хамтран Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага (UNIDO)-ын тусламжтай боловсруулсан “Монгол Улсын аж үйлдвэрийн салбарын өрсөлдөх чадварын үнэлгээ”-г хэвлэн олны хүртээл болголоо. Судалгаа нь Монгол Улсын аж үйлдвэрийн салбар, дэд салбарын урьдчилсан үнэлгээг

гаргах, улмаар Үйлдвэр, Худалдааны яамнаас аж үйлдвэрийн хөгжлийн дунд хугацааны болон хэтийн стратегийг боловсруулахад шаардлагатай мэдээллээр хангах зорилготой байв. Монголын аж үйлдвэрийн салбарын үндсэн үзүүлэлтүүдийг ижил төстэй эдийн засаг бүхий болон хөгжингүй

улс орнуудын үзүүлэлттэй харьцуулах замааражилчдын мэргэжлийн урчадвар, технологийн түвшин, гадаадын шууд хөрөнгө оруулалт, салбарын хэмжээнд олгосон патент, тусгай зөвшөөрлийн тоо хэмжээ болон дэд бүтцийн хөгжил гэсэн хүчин зүйлсийг жишин тогтоосон болно.

ОРОН НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ

Сумын түвшинд орон нутгийн эдийн засгийг иргэдийн өөрсдийнх нь оролцоо, дэмжлэгтэйгээр хөгжүүлэх зорилгоор 2006 оноос эхлэн Нээлттэй Нийгэм Форум Будапешт дахь LGI буюу Нутгийн Захиргааны Санаачилга байгууллагатай хамтран “Оролцогчдын хамтын ажиллагаанд тулгуурлан орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх/ ДЕЛТА” төслийг хэрэгжүүлж байна.

2007 оны хувьд орон нутгийн засаг захиргаа, бизнесийн чадавхийг бэхжүүлэх зорилгоор гуравдахь удаагийн сургалт семинарыг хийж, төсөлд хамрагдсан дөрвөн сумын Засаг дарга нарын туршлага солилцох уулзалтыг Увсын Тариалан, Хөвсгөлийн Тариалан суманд тус тус зохион байгууллаа.

Төслийн хүрээнд сумын түвшинд бодлогын шинэчлэл хийж, хувийн хэвшлийг хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, төрийн болон хувийн хэвшлийн түншлэлийг



институцчилах, бизнесийн орчинг илүү сайн хөгжүүлэхэд чиглэсэн стратеги, алсын хараа бий болгоход чиглэсэн хамтын ажиллагааг өрнүүлсээр ирлээ. Ийнхүү олон удаагийн сургалт семинар, судалгаа шинжилгээ, орон нутгийнхны уулзалт ярилцлага, хэлэлцүүлгийн үр дүнд ДЕЛТА төслийг хэрэгжүүлсэн дөрвөн сум болох Хөвсгөл аймгийн Тариалан, Архангай аймгийн Ихтамир, Увс аймгийн Тариалан, Баянхонгор аймгийн Баянхонгор сумд дунд хугацааны эдийн засгийн хөгжлийн стратегиа боловсрууллаа. Тухайн сумын иргэдийн амьдралд туйлын ач холбогдолтой төслүүдийг санхүүжүүлэх “Хөрөнгө оруулалтын сан”-г байгуулж, нийт зургаан төсөл хэрэгжүүлэхээр сонгон санхүүжилтээр хангав. Төслүүдийн хэрэгжилтэд мониторинг хийх ажлыг эхлэхээр төлөвлөөд байна.

Стратегийг сурталчлах, энэхүү баримт бичгийн талаарх мэдээллийг түгээх, улмаар хэрэгжүүлэх үүднээс ННФ

Бодлого Судлалын Төвтэй хамтран бусад ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг төсөл, хөтөлбөр, хандивлагчид, банк санхүүгийн байгууллага болон Засгийн газрын төлөөллийг оролцуулан Донор форумыг зохион байгууллаа. ДЕЛТА төслийн талаарх ерөнхий ойлголт, арга зүй, мэдээ, мэдээллээр хангах, сумдын стратегийг сурталчлах, олонд хүргэх зорилгоор веб сайт үүсгэх санаачилга хэрэгжиж байна.

Цаашид орон нутгийн засаг захиргаа, бизнесийн байгууллагуудыг зах зээлийн мэдээллээр хангах, бусад үйлчилгээг үзүүлэх зорилгоор төслийн хүрээнд байгуулагдсан Орон нутгийн бизнесийн хөгжлийн алба тухайн нутаг орон дахь стратегийн биелэлтэд хяналт тавин ажиллах юм.

Энэхүү төслийн арга зүйг бусад хандивлагч байгууллага болон УИХ-ын зарим гишүүн сонирхон судалж хэрэгжүүлэх болсон нь бидний хувьд олзуурхууштай хэрэг боллоо.



УУЛ УУРХАЙН САЛБАРЫН БОДЛОГЫН АСУУДАЛ



Эдийн засагт эзлэх байр суурь нь тэлж байгаа ашигт малтмалын салбарын хөгжлийн ирээдүйн асуудал 2007 онд Монголын нийгмийн анхаарлын төвд байлаа. Асар их нөөцтэй нь тогтоогдсон зэс, алтны Оюу Толгой, нүүрсний Таван Толгойн орд газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах, олох ашгийг нь ард түмэнд шударга, тэгш хүртээх талаар улстөрчид, эрдэмтэд судлаачид, жирийн иргэд ч санал бодлоо уралдууллаа. Энэ үйл явцад оролцохдоо Нээлттэй Нийгэм Форум нь томоохон төслүүдийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын хувилбаруудыг тодорхойлоход түлхүү анхаарч ажиллалаа. Чингэхдээ АНУ-д төвтэй “Орлогын Ажиглагч” Хүрээлэнтэй хамтран бодлогын зөвлөгөө бэлтгэн хэлэлцүүлэг өрнүүлэв. Тухайлбал, Оюу Толгойн орд газрыг ашиглах талаар Айвенхоу Майнз, Рио Тинто компанитай хийх Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг Засгийн газраас боловсруулан УИХ-д өргөн барьсантай холбогдуулан

уг төсөлд богино хугацаанд иж бүрэн дүн шинжилгээ хийж олон нийтэд танилцуулсан нь нийгэмд олон талын оролцоотой өргөн хэлэлцүүлэг өрнөх нэг гол нөхцөл болсон юм.

Уг гэрээг үнэлэн цэгнэх зорилгоор УИХ-ын Эдийн Засгийн Байнгын Хороотой хамтран Ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, ННФ-ын дүн шинжилгээг УИХ-ын гишүүд болон ажлын хэсгийн гишүүдэд танилцуулж ярилцсан нь үр дүнтэй ажил болсон юм. Уулзалтын үеэр бодлого боловсруулагчдаас тавьсан хүсэлтийн дагуу нэмэлт дүн шинжилгээ хийж үр дүнг нь хүргэсэн болно. Гэрээнд үнэлгээ хийх зорилгоор боловсруулсан эдийн засгийн загварыг энэ үеэр танилцуулж, сонирхсон талуудад бүрэн эхээр нь хүлээлгэн өглөө.

Оюу Толгойн ашиглалтын талаар янз бүрийн байр суурьтай иргэний нийгмийн байгууллагуудын дунд дээрх дүн шинжилгээнд тулгуурласан ярилцлага өрнүүллээ. Ингэхдээ уг төслийн эдийн засаг, байгаль орчин, нийгмийн үр нөлөөнд анхаарал хандуулж, улстөржихгүй байхыг эрмэлзсэн болно. Түүнчлэн уг гэрээтэй холбоотой болон шууд холбоогүй бусад асуудлаар ч УИХ-ын гишүүд, Засгийн газарт өөрсдийн судалгаа, байр суурийг танилцуулж байв. Тухайлбал, уул уурхайн салбар дахь төрийн өмчийн оролцоо, гэнэтийн ашгийн татвар, төсөв санхүүгийн тогтолцоо зэрэг олон асуудлаар судалгаа хийсэн болно.

ГАЗРЫН ШИНЭТГЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Нээлттэй Нийгэм Форум өмнөх жилүүдэд газрын харилцааны шинэтгэлийн асуудлаар цуврал арга хэмжээ авч хэрэгжүүлж байсан ба 2007 онд Газрын Харилцаа, Геодези, Зураг зүйн Газартай хамтран ажиллаж, “Сайн газрын харилцаа, түүний эдийн засгийн хөгжилд гүйцэтгэх үүрэг” сэдэвт олон улсын бага хурлыг зохион байгуулах,

хурлын үр дүнгээр товхимол бэлтгэхэд дэмжлэг үзүүллээ. Энэ бага хурлаар шилжилтийн гэгдэх Зүүн Европын улс орнууд, Азийн зарим орны газрын харилцааны талаар ярилцаж туршлага солилцсон нь Монгол Улсад газрын шинэтгэлийг гүнзгийрүүлэх бодлогыг боловсруулахад ихээхэн ач холбогдолтой болсон юм.

ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ЯРИА ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Нээлттэй Нийгэм Форум Монгол Улсын хөгжлийн чиг баримжааны талаар өргөн хүрээтэй бодлогын яриа хэлэлцүүлэг өрнүүлэх, эдийн засгийн голлох асуудлаарх судалгаа, шинжилгээг сайжруулах явдалд байнга анхаарч байна.

“Үндэсний хөгжлийн яриа хэлэлцүүлэг” хэмээх тусгай механизм бий болгох санаачилгыг ННФ 2005 оноос эхлүүлсэн бөгөөд энэ нь үндэсний хөгжлийн асуудлуудаар мэргэжилтнүүдийн дунд тогтмолуулзалт ярилцлага зохиох замаар

бодлогын хувилбаруудыг дэвшүүлэх үнэлгээ өгөх, цаашлаад эдийн засгийн шийдвэрлэх сонголтуудыг хэлэлцэн тохироход хувь нэмрээ оруулах учиртай юм.

Дээрх зорилгын хүрээнд 2007 онд авч хэрэгжүүлсэн томоохон ажлын нэг нь Монголын төрийн болон эдийн засгийн бодлогыг шилжилтийн хүнд хэцүү цаг үед тодорхойлон Засгийн газрыг удирдаж байсан Ерөнхий сайд нарын үгийг эдийн засгийн чухал асуудлуудаар сонсох зорилго бүхий “Монгол Улсын Ерөнхий



сайд нар ярьж байна” цуврал уулзалт ярилцлага юм. Тухайлбал Ерөнхий сайд асан Д. Содном “Ашигт малтмалын ордыг үр ашигтай ашиглах асуудалд”, Д. Бямбасүрэн “Монгол Улсын төрийн тогтолцооны одоогийн байдал, түүнийг хөгжүүлэх гол чиглэлүүд”, Ш. Гунгаадорж “Монгол Улсын хөдөөгийн болон хөдөө аж ахуйн хөгжлийн зарим асуудал”, П. Жасрай “Монголын эдийн засгийн ойрын ирээдүйн бүтэц, хөгжил”, Р. Амаржаргал “Зүүн Хойд Азийн чөлөөт худалдааны гэрээ ба Монгол” зэрэг асуудлаар илтгэл тавьж хэлэлцүүлсэн байна. ННФ эдгээр илтгэлийг цуврал болгон хэвлүүлж уншигчдын гарт хүргэлээ.

Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Монгол Улсын 2021 он хүртэлх үндэсний хөгжлийн цогц бодлогын төслийг УИХ-аар хэлэлцүүлж батлахаас өмнө олон нийтийн санаа бодлыг тусгах үүднээс Монгол Улсын Засгийн Газрын Үндэсний хөгжлийн цогц бодлого боловсруулах ажлын хэсэгтэй хамтран

уулзалт хэлэлцүүлэг зохион байгууллаа. Энэхүү хэлэлцүүлэгт УИХ-ын гишүүд, тэргүүлэх эдийн засагчид, төрийн бус байгууллагууд болон иргэд оролцож өөрсдийн санал шүүмжийг харамгүй өгсөн юм. Уг хэлэлцүүлгийн бэлтгэл ажил болгон гол салбар асуудлаар хэд хэдэн эдийн засагч, мэргэжилтний дүгнэлт, санал шүүмжийг авсан нь хэлэлцүүлгийг амжилттай явуулах болон ажлын хэсгийг тодорхой саналаар хангахад чухал алхам боллоо.

ННФ Монгол дахь эдийн засгийн эрх чөлөөний түвшин, өрсөлдөх чадвар, төсөв, уул уурхайн бодлогууд ба бусад чиглэлээр хийж байгаа судалгаагаа 2007 онд үргэлжлүүлэх замаар эдийн засгийн бодлогын шинжилгээ, яриа хэлэлцүүлгийг хөхиүлэн дэмжиж ажиллалаа.



НИЙГМИЙН БОДЛОГО

БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН АСУУДЛУУД

Нээлттэй Нийгэм Форум 2007 онд боловсрол, нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр ажиллаж буй түнш төрийн бус байгууллагууд, бие даасан шинжээчдэд тэтгэлэг олгон үйл ажиллагааг нь дэмжин ажиллалаа.

Тухайлбал, боловсролын чанар, сургалтын арга зүй, багш нарыг хөгжүүлэх чиглэлээр дагнан ажилладаг Монголын Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг ТББ-ын “Илтгэл, мэтгэлцээний боловсрол”, “Алхам алхмаар” хөтөлбөрүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна. Өсвөр үеийнхэн, ахлах ангийн сурагчдын шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхэд нь туслах зорилготой “Илтгэл, мэтгэлцээний боловсрол” хөтөлбөрөөс 2007 оны 7-8 дугаар сард Чех улсад зохион байгуулагдсан олон улсын мэтгэлцээний форумд Монгол сурагчдыг бэлтгэн амжилттай оролцон багаараа шагналт байранд орсон байна. “Алхам алхмаар” хөтөлбөрийн хүрээнд сургуулийн өмнөх боловсрол, бага насны хүүхдүүдийн сургалтын

арга зүй болон материал боловсруулах үйл ажиллагааг цогцоор хэрэгжүүлж байна. Тухайлбал сургуульд хүүхдээ хэрхэн бэлтгэх талаар эцэг эхчүүдэд сургалт явуулах, бага насны хүүхдийг хөгжүүлэх орчин болон сургалт, арга зүйн түшиц цэцэрлэгүүдийг байгуулж ажиллуулах, хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхдийг тэгш хамруулах зэрэг шинэлэг арга хэлбэрийг туршин ажиллахад нь ННФ дэмжлэг үзүүлээ.

Дэлхийн Банкны “Хөгжлийн зах” хөтөлбөрт ННФ түнш болж оролцсон бөгөөд тус хөтөлбөрт ирүүлсэн ТББ, хувь хүмүүсийн төслүүдийг хоёр үе шаттайгаар шүүн шалгаруулах, шалгарсан төслүүдийг олон нийтэд танилцуулах ажилд идэвхтэй хамтран оролцлоо. Түүнчлэн харааны бэрхшээлтэй хот, хөдөөгийн иргэдэд эрх зүйн боловсрол олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх санал дэвшүүлсэн Эрх Чөлөө Төв ТББ-ын төслийг ННФ санхүүжүүллээ. Энэ хөтөлбөрийн хүрээнд Эрх Чөлөө Төв нь брайль болон кирилл үсгээр “Эрх зүйн мэдлэгийн үндэс” гарын авлагыг хэвлүүлж, хараагүй иргэдэд зориулж хоёр удаа сургалт зохион байгуулжээ.

2007 онд Боловсролын Зөвлөгөө, Мэдээллийн Төв ТББ-ын үндсэн үйл ажиллагааг дэмжиж ННФ-аас тэтгэлэг олголоо. Энэ байгууллага нь гадаад, дотоодод боловсрол эзэмших боломж, сургалтын тэтгэлэгт хөтөлбөрийн талаарх мэдээллийг хот, хөдөөгийн залууст хүргэхийн зэрэгцээ англи хэлний сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг бөгөөд Улаанбаатар хотоос гадна хөдөө орон нутгийн залуучуудад хүрч ажиллах гурван салбар нээгээд байгаа нь уг байгууллагын нэг давуу тал юм.

Улсын төсвийн нэлээд хэсгийг эзэлдэг эрүүл мэнд, боловсролын салбарын төсвийн үр ашгийг дээшлүүлэх замаар нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийг улам сайжруулах талаар Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд гурван судалгааг хийгэлээ. Эрүүл мэндийн салбарын санхүүгийн нөөцийг илүү оновчтой хуваарилах асуудлыг судалж буй судлаач Д.Чимиддагва хүн амын эрүүл мэндийг хамгаалахад хамгийн их өгөөжтэй байдаг урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд энэ салбарын хөрөнгийн дөнгөж 5 хувь зарцуулагдаж байгааг эрс нэмэгдүүлэхийн зэрэгцээ өвчин, гэмтлээс болж ядууралд орох эрсдлийг хаах зорилгоор Эрүүл мэндийн даатгалаас салбараа түлхүү

санхүүжүүлдэг тогтолцоо руу шилжих шийдлийг санал болгоод байна. Мөн эрүүл мэндийн байгууллагын төсвийн зарцуулалтын үр ашгийг үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжаар хэмжих шийдлийг эмчлүүлэгчид болон эмч нараас авсан судалгааны материалд тулгуурлан судлаач Л. Мөнх-Эрдэнэ дэвшүүлжээ. БСШУЯ-ны жилийн төсвийн багагүй хэсгийг эзэлдэг эмзэг болон ядуу өрхийн хүүхдийг үнэгүй сурах бичгээр хангах бодлогын хэрэгжилтийн өнөөгийн байдалд үнэлгээ өгч, цаашид анхаарах бодлогын асуудлуудыг тодорхойлох ажлыг судлаач Д.Нарантуяа гүйцэтгэж байна.

ННФ хүнсний аюулгүй байдал бодлогын түвшинд онцгой анхаарах чухал асуудал болоод байгааг анхааралдаа авч бодлогын судалгааны хөтөлбөрийн хүрээнд энэ чиглэлийн гурван судалгааг мөн дэмжлээ. Тухайлбал, судлаач Б.Арвинбаяр хүнсний бүтээгдэхүүний импортод тавих хяналтыг сайжруулах зорилгоор хилийн шалган нэвтрүүлэх боомтуудын үйл ажиллагаанд ажиглалт хийж, бусад орны нөхцөл байдал, тэдний хууль эрх зүйн орчин, хяналт тавих механизмуудтай харьцуулсан тодорхой бодлогын шийдлийг санал болгожээ.

ФОРУМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЭЛ

ХӨГЖЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТӨВ

Форумын үйл ажиллагааг хэрэгжүүлэх нэг хэрэгсэл болох Хөгжлийн Мэдээллийн төв үйл ажиллагаагаа эхлээд дөрвөн жил боллоо. Өнгөрсөн хугацаанд бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаарх ном, судалгааны тайлан, үнэлгээ, бодлогын баримт бичиг, статистик мэдээлэл, бусад орны туршлага зэрэг цогц мэдээллийг нэг цэгээс олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй хүргэхэд гол анхаарлаа хандуулж ирлээ.

2007 онд Мэдээллийн төв сард 250-300 хүнд үйлчилгээ үзүүлж, 1200 байнгын карттай үйлчлүүлэгчтэй болжээ. Түүнчлэн давхардсан тоогоор 6000 орчим ном судалгаа гэрээр, танхимд түүнээс 2-3 дахин олон ном ашиглагдсан байна. Түүнчлэн жилд 400-500 шинэ ном, судалгаа каталогид нэмж бүртгэгдэн нийтдээ 3200 төрлийн 5000 орчим хэвлэмэл мэдээлэлтэй боллоо.

Форумаас гарч буй шинэ ном, судалгааг түгээх үйл ажиллагаа өргөжиж хөдөө



орон нутаг болон их дээд сургуулийн номын сан, судалгааны төв, төрийн болон төрийн бус байгууллагуудад 2007 онд 20 мянга орчим ном тараалаа. Мэдээллийн төвд шинээр ирж байгаа болон Форумгаас гаргаж буй шинэ ном, судалгааны тухай Мэдээллийн хуудсыг (Newsletter) улирал тутамд бэлтгэж мэйлийн группээр тарааж байна.

Дэлхий нийтээр хэрэглэж буй электрон мэдээллийн сан, и-номын санг тус Төвөөр дамжуулан хэрэглэгчдэд хүргэх гэрээнд нэгдэж Кэмбриджийн 150 гаруй онлайн сэтгүүл, Оксфордын лавлах ном, толь бичгүүд, Дэлхийн Банкны и-номын сан зэргийг карттай уншигчид үнэ төлбөргүй ашиглаж байна. Мөн эдгээр электрон эх сурвалж болон EBSCO мэдээллийн санг олон нийтэд танилцуулах уулзалт семинар, сургалт, хөгжлийн сэдвээр олон нийтэд зориулсан лекц, шинэ номын нээлт зэрэг олон арга хэмжээг зохион байгуулав. Тухайлбал, жил бүрийн техникийн уулзалтын дараа Дэлхийн Банкны Монголыг хариуцсан захирал, доктор Давид Доллар иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчдөд зориулан лекц уншдаг уламжлал тогтлоо. 2007 онд “Уул уурхай: Монголчуудын амьдралыг сайжруулах боломж нөхцөл” сэдвээр уншсан лекцэд 70 орчим хүн оролцож уул уурхайн хөгжлийн чиглэлээр донор байгууллагын баримтлах чиг хандлагыг асууж сонирхсон байна.

МУИС, Дархан хотын нийтийн номын сан дээр нээгдсэн Төвүүдээр дамжуулан хөгжлийн мэдээлэл түгээхээр болж 2007 онд Нээлттэй Нийгэм Форум, Дэлхийн Банк, НҮБ хамтран ажиллах Санамж бичигт гарын үсэг зурав. Энэ үйл ажиллагааны үр дүнд судлаач багш нар, оюутнууд, хөдөө орон нутгийн иргэд Монголын хөгжлийн талаар гарсан судалгааны материалтай танилцах боломжоор хангагдлаа. Орон нутгийн номын санчдыг дэмжих “Сайн дурын хөтөлбөр”-т 21 аймаг, МУИС болон Боловсролын Зөвлөгөө Мэдээллийн Төвийн нийт 45 номын санч оролцож Мэдээллийн төвийн үйл ажиллагаатай танилцан электрон каталоги ашиглах, онлайн үйлчилгээ хүргэх, шинэ ном, судалгааг сурталчлах чиглэлээр харилцан туршлага солилцлоо. Энэ нь ННФ-аас түгээж буй мэдээллийг олны хүртээл болгоход тус нэмэр болов.

Ном бүртгэл, үйлчилгээний статистик гаргах, ном олгох, сонины хайчилбар бүрдүүлэх ажиллагааг програмжуулсан нь үйлчилгээний ажлыг хөнгөвчилж цаашид Төвийн үйлчилгээг онлайнаар хүргэх, электрон мэдээллийн сангаар түлхүү үйлчлэх боломжийг бүрдүүлж байна.

Нээлттэй Нийгэм Форум нь нийгмийн амьдралд иргэд, иргэний нийгмийн идэвхтэй оролцоог дэмжих зорилготой. Манай вэб Та бүхэнд Монгол Улсад бодлого боловсруулалт, хэрэгжүүлэлтийн салбарт болж буй сүүлийн үеийн үйл явдлын талаар мэдээ, мэдээлэл, судалгааны бусад сонирхолтой материалыг хүргэх болно.

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ
OPEN SOCIETY FORUM

English

НҮҮР НИЙТЛЭЛ БОДЛОГЫН АСУУДАЛ ЭХ СУРВАЛЖ NEWS HEADLINES ФОРУМЫН ТӨСЛҮҮД ҮЙЛ ЯВДАЛ БИДНИЙ ТУХАЙ

АЖИГЛАЛТ

- СОНГУУЛЬ
- ТӨСӨВ
- УУЛ, УУРХАЙ-ХӨГЖИЛ
- ДОНОРУУДЫН ТУСЛАМЖ

НИЙТЛЭЛ

Төрийн албаны шинэчлэлийн зарим асуудал
(2007.04.17)
[0 санал] *Д.Оюунчимэг*
Хүний нөөцийн хөгжлийн төв ТББ-ын тэргүүн, судлаач

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

- Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл (2007.02.06) PDF

NEWS HEADLINES

Гэнэтийн ашгийн татвар Үндсэн хууль зөрчөөгүй хэмээн Цэц үзлээ (2007.04.19)
Алт олборлодог компаниуд гэнэтийн ашигийн татвар хураалгаж байгаа нь Үндсэн хууль зөрчсөн хэмээн үзэж Баянгол дүүргийн иргэн Б.Баяраа Үндсэн хуулийн Цэцэд гомдол гаргасныг хянан ... *Дэлгэрэнгүй>>*

Оюутолгойн ордод Монголын эзэмших хувь 34 байхаар тохиролцжээ

NEWS HEADLINES : Өмнөх мэдээнүүд>>

БОДЛОГЫН АСУУДАЛ : Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Монгол Улсын үндэсний хөгжлийн цогц бодлого (Төсөл PDF)

БОДЛОГЫН АСУУДАЛ

- УИХ-ын Сонгуулийн хуулийг дагалдан гарах журмуудын төслүүд (2007.03.14) [0 санал]

ҮЙЛ ЯВДАЛ

Төсөлд оролцох талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх уулзалтад болов
ННФ-ын журлын танхимд 15:00 цагт [2007.04.13]

Мониторингийн туршлага солилцох, түншлэх уулзалт боллоо
ННФ-ын журлын танхимд 15:00 цагт [2007.04.10-12]

“Нээлттэй Нийгэм Форум” портал сайт нь Монгол дахь нь бодлого боловсруулах үйл явц, бодлогын шийдвэрийн талаарх мэдээллээр олон нийтийг хангах замаар тэдний оролцоог бүрдүүлэх, бодлогод хяналт шинжилгээ хийх, үнэлэх зэргээр олон талт байр суурийг түгээх, сонирхогч олон нийт өөр хоорондоо санал солилцох хэлэлцүүлгийн талбарыг бүрдүүлэх зорилгоор 2003 оны 10 дугаар сард байгуулагдсан. Монгол, англи хэлээр гардаг бөгөөд нийтлэл /нийт 262/, бодлогын асуудал, эх сурвалж, хэлэлцүүлэг, ажиглалт зэрэг үндсэн хэсгээс бүрддэг. Энэ хугацаанд Ерөнхийлөгчийн, парламентын болон

орон нутгийн сонгуулиудын талаар тогтмол ажиглалт явуулж эдгээр үйл явцын тухай бүх мэдээллийг нэг дороос үзэх боломжийг олголоо. Монголд анх удаа улсын төсвийн үйл явц, уул уурхайн салбарын хүрээнд өрнөж буй бүхий л мэдээллийг агуулсан портал болохыг эрмэлзсэн. Манай порталд нийт 610000 хүн, сард дундажаар 14500, өдөрт дундажаар 500 гаруй хүн нэвтэрч хэрэгцээтэй мэдээллээ авсны зэрэгцээ 1600 орчим хүн тухайн сэдэв, асуудлаар санал бодлоо илэрхийлжээ. 2007 онд дараахь ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

Нийтлэл

Монголын хөгжлийн талаарх олон янзын байр суурийг агуулсан дүн шинжилгээ бүхий 50 гаруй нийтлэл, өгүүллийг олны хүртээл болголоо. Чингэхдээ өмнөх онд улстөр, төсөв, мэдээллийн эрх чөлөөний тухай асуудлууд түлхүү тусгагдсан байсныг харгалзан эдгээрээс бусад цөөнтэй тоотой өгүүлэл агуулсан сэдвүүдийг тодорхой хэмжээгээр хөндөхийг зорьсон болно. Үүний үр дүнд эдгээр сэдвээс гадна засаглалын асуудлууд, татвар, уул уурхай, байгаль орчин, хүн амын амьжиргаа, хүнс, хөдөө аж ахуй, гадаад, дотоод бодлого, даяаршлын асуудлыг хөндсөн нийтлэлээр баяжсан бөгөөд эрдэмтэн судлаачид, багш нар, сэтгүүлч, төрийн албан хаагч зэрэг давхардсан тоогоор 54 гаруй хүн өөрсдийн бичсэн нийтлэл, өгүүллээ нийлүүлжээ. Мөн “Орчуулгын нийтлэл” буланд гадаадын нэр хүнд бүхий авторуудын зохиол бүтээлээс орчуулж таниулах ажлыг үргэлжлүүлэн хийлээ.

News headlines

Энэ булангаар бид тухайн өдрийн Монголын улстөр, эдийн засгийн онцлог үйл явдлын талаарх тойм мэдээллийг тогтмол хүргэдэг. 2005 оны сүүлээр эхэлсэн энэ буланд эдүгээ 265 гаруй үйл явдлын тухай мэдээлэл хуримтлагджээ. Тойм өгүүллийг өдөр тутмын сонин хэвлэлүүдийн мэдээлэлд үндэслэн өдөр бүр байнга шинэчилдэг бөгөөд эндээс Монголын хувьд тухайн жил сард бодлогын холбогдолтой ямар үйл явдлууд өрнөж олон нийтийн анхаарлыг

татаж байсныг харах бүрэн боломжтой юм.

Тогтмол явуулдаг ажиглалтууд:

Сонгуулийн ажиглалт

Улсын Их Хурлын болон Орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн сонгуулийн үр дүнд бий болсон улстөрийн нөхцөл байдалтай холбогдуулан Монголын улстөрийн хүрээнд өрнөж буй үйл явдлыг тогтмол мэдээлж байна. Мэдээллийг бэлтгэхдээ намуудын амлалт Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хүрээнд хэрхэн хэрэгжиж буй байдлыг илүүтэй харгалзан үздэг бөгөөд энэ хэсэгт 2007 онд 110 гаруй мэдээллийг шинээр оруулжээ.

Уул уурхай – Хөгжил

2007 он өмнөх жилийн адил Монголын уул уурхайн салбарын хувьд ихээхэн онцлог жил болж өнгөрлөө. “Айвенхоу Майнз” компанитай хийх Засгийн газрын гэрээ хойшлогдсон хэвээр байгаа бөгөөд Таван толгой зэрэг томоохон орд газарт хийх хөрөнгө оруулалтын гэрээний асуудал ч олны анхаарлын төвд орж ирлээ. Засгийн газар болон иргэдийн хөдөлгөөн, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөлтэй ажлын хэсэг байгуулагдан ажиллаж эхлэв. Энэ бүхий үйл явдлын талаарх цогц мэдээллийг манай портал хүргэсээр ирсэн агаад 2007 онд 100 гаруй мэдээллийг олон нийтэд хүргэлээ. Түүнчлэн стратегийн орд газруудын жагсаалтыг УИХ-аас баталсантай холбогдуулан эдгээр ордын мэдээллийг

агуулсан тусгай хуудас шинээр эхлүүлсэн нь нэлээд ач холбогдолтой үйл ажиллагаа болсон юм. Одоогоор Оюу Толгой, Таван Толгой, Асгатын ордын талаарх мэдээллийг цуглуулж эхлээд байна.

“Төсвийн үйл явц”

Тус портал нь 2004 оноос эхлэн жил бүрийн улсын төсвийг УИХ-аар хэлэлцэн батлах үйл явц, төсвийн хүрээний тодотголтой холбоотой багц мэдээллүүдийг тогтмол толилуулдаг болсон. Тайлангийн хугацаанд 2007 оны төсвийн тодотгол, тухайлбал, төсөв ерөнхийлөн захирагчдын зарлага, орлого, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, гадаад зээлийн ашиглалт, төлбөр зэрэгт холбогдох нийт 80 мэдээ, мэдээллийг түгээлээ. 2008 оны улсын төсвийн дэлгэрэнгүй төслийг бүрэн эхээр нь веб сайтад байрлуулж, олон нийтийн санал бодлыг нь хүлээн авлаа.

“Доноруудын тусламж”

Олон улсын байгууллага, хандивлагчдаас Монгол Улсад үзүүлж буй тусламж, зээлийн талаарх мэдээллийг хэвлэл мэдээллээр хэрхэн хүргэж буйг ажиглах зорилгоор “Доноруудын тусламж” ажиглалтыг 2007 онд шинээр эхлүүлээ. Тайлант хугацаанд олон улсын донор байгууллагуудын тусламжаар хэрэгжүүлж буй төсөл, гэрээний талаарх 30 орчим мэдээллийг олон нийтэд хүргэсэн бөгөөд энэ талын

бүх мэдээллийг эх сурвалжаас нь авч баяжуулахыг зорьж байна.

Бодлогын асуудал

“Бодлогын асуудал” буланд хууль тогтоох үйл явц дахь иргэдийн оролцоог боловсронгуй болгоход чиглэсэн холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын төсөл, УИХ-ын Сонгуулийн хуулийг дагалдан гарах журмууд /нийт 15 журам, 13 баримт бичгийн төсөл/, Мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай хуулийн төсөл зэрэг баримт бичиг, тэдгээртэй холбоотой судалгаа, санал зөвлөмжийг багцлан толилуулсан байна. Тайлант хугацаанд 40 гаруй мэдээллийг шинээр оруулсан бөгөөд эдгээр асуудлаар нийт 40 гаруй хүн санал бодлоо илэрхийлжээ.

Эх сурвалж

2007 онд Монголын нийгэм, эдийн засгийн хөгжлийн сэдвээр донор байгууллагууд болон бусад судалгааны төвийн хийсэн 40 орчим шинэ судалгааг бүрэн эхээр нь pdf форматаар байрлуулав. Мөн бодлогын асуудлаар хэвлэгдэж буй ном товхимол, гарын авлагуудыг танилцуулжээ.

2007 онд портал сайтад нийт 150 гаруй мянган хүн, өдөрт дундажаар 600 орчим хүн нэвтэрчээ. 600 орчим мэдээллээр порталын мэдээллийн сан арвижсан байна.

БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

Нээлттэй Нийгэм Форум хавсарга судалгааны нэг чиглэл болох бодлогын судалгаа, дүн шинжилгээг Монголд хөгжүүлэх зорилгоор Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийг 2004 оноос эхлэн хэрэгжүүлж байна. Бодлого боловсруулах үйл явцыг бие даасан шинжээч, судлаачдын санал, зөвлөмжөөр баяжуулахын зэрэгцээ тодорхой асуудлаар хувилбарт шийдлүүдийг дэвшүүлэн олон нийт, бодлого боловсруулагчдын дунд бодлогын яриа, хэлэлцүүлэг өрнүүлэх боломжийг бүрдүүлэх зорилготой уг хөтөлбөр нь нээлттэй өрсөлдөөний зарчмаар хувь судлаач, шинжээчдийг элсүүлэн авч, 6-10 сарын хугацаанд судалгаа хийх боломжоор хангадаг юм.

2007 онд ННФ нь хоёр удаагийн элсэлтээр нийт 21 судлаачийг хөтөлбөрт хамруулсан бөгөөд эхний элсэлтийн 14 хүнд бодлогын судалгааны арга зүй, бодлогын баримт бичиж боловсруулах аргачлал, судалгааны үр дүнг олон нийтэд хүргэх нөлөөллийн үйл ажиллагааны стратегийн талаар гурван удаа сургалт зохион байгууллаа. Сургалтын үр дүнд судалгааны үр дүнг зөвлөмж тайлан хэлбэрээр олон нийтэд хүргэхийн зэрэгцээ судлаачид “Бодлогын тойм” хэмээх баримт бичгийг бичиж боловсруулах арга зүйд суралцсан нь энэ жилийн хөтөлбөрийн шинэлэг тал болсон юм. Сургалтуудыг Канадын Оттава хот дахь Карлтоны Их сургуулийн Төрийн захиргаа, бодлогын сургуулийн багш Лесли Пал, Унгар дахь Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн “Орон Нутгийн

Засаглалыг Бэхжүүлэх Санаачилга” хөтөлбөрийн Бодлогын судалгааны сургалт хариуцсан захирал Оуэн Янг нар удирдан явуулсан бөгөөд сургалтын өмнө болон дараа судлаачидтай харилцан унших материалаар хангахын хамт судалгаа тус бүрт холбогдох зөвлөмжийг өгсөн нь чухал үр дүнтэй ажил болов.

Тэтгэлэгт хөтөлбөр нь судлаачдад сарын тэтгэлгээс гадна ном, зохиол худалдаж авах, олон улсын болон дотоод, гадаадын хуралд оролцох, анхдагч мэдээлэл цуглуулах зэрэгт холбогдох зардлыг олгодог. 2007 оны судлаачдаас хурал, уулзалтад илтгэл тавьж оролцох хүсэлт гараагүй хэдий ч судлаачид өөрсдөө судалгааны тодорхой дүгнэлтийг хэлэлцэх, тайлангийн эх бичвэр дээр санал шүүмж авах зорилгоор 10-аад удаагийн уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулсан байна. Захиалсан номыг ННФ-ын Хөгжлийн Мэдээллийн төвөөр дамжуулан судлаачдад хүргэдэг болно.

Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийн судлах асуудлын гол чиглэлийг ННФ өөрийн үндсэн үйл ажиллагаатай уялдаатай байдлаар тодорхойлон үндэсний өдөртутмын сонин хэвлэлээр зарласны дагуу судлаачид асуудлаа нарийвчлан томъёолж санал ирүүлдэг зарчмыг тайлант хугацаанд баримталж ажиллалаа. 2007 оны эхний хагаст ННФ-аас зарласан 15 сэдвийн дагуу 120 гаруй судлаач судалгааны ажлын нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж ирүүлснээс нийт 14 судлаачийг шалгаруулан ажиллууллаа.

2007 оны эхний сонгон шалгаруулалтаар эхлүүлсэн судалгаа

Судлаачийн нэр	Сэдэв
Сумьяагийн Оюунтуяа, <i>Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд ТББ-ын зохицуулагч</i>	Ашиг сонирхлын зөрчил
Эрдэнэбилэгийн Гэрэлт-Од, <i>МУИС-ийн багш</i>	Улс төрийн намыг институтчилах үйл явцын эрх зүйн орчинг сайжруулах нь
Сэнгэдоржийн Түмэндэлгэр, <i>МУИБС-ийн багш</i>	Орон нутгийн түвшин дэх иргэдийн оролцоо: Нийслэлийн ИТХ
Гэрэлхүүгийн Түмэннаст, <i>МУИС-ийн багш</i>	ИТХ-ын бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог хангах нь: аймаг, сумын ИТХ
Данзангийн Нарантуяа, <i>АХБ-ны төсвийн орон нутгийн зөвлөх</i>	Ерөнхий Боловсролын Сургуулийн сурах бичгийг төлбөртэй болгох бодлого
Дашзэвэгийн Чимиддагва, <i>"Макро эдийн засаг ба эрүүл мэнд" ТББ-ын тэргүүн</i>	Эрүүл мэндийн салбарын хөрөнгийн хуваарилалт
Лувсангийн Мөнх-Эрдэнэ, <i>Нийгмийн Эрүүл Мэндийн сургуулийн багш</i>	Эмнэлгийн санхүүжилтийн үр ашиг, үйлчилгээний чанар
Лхамсүрэнгийн Мөнх-Эрдэнэ, <i>МУИС-ийн тэнхмийн эрхлэгч</i>	Их дээд сургуулийн удирдлагын асуудал
Чимидийн Базар <i>/сэтгүүлч, докторант/</i>	Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хөгжил
Өсөхийн Батсайхан,	Төрийн бодлого дахь хөдөөгийн хөгжлийн асуудал
Хүүхэнбаатарын Ганзориг	Хүнсний аюулгүй байдал ба төрийн хяналт
Баатарын Арвинбаяр	Хүнсний аюулгүй байдлыг хангах урьдчилан хяналтын тогтоцоог бэхжүүлэх эрх зүйн орчин
Сэнгэдоржийн Мөнхбаатар	Хүнсний аюулгүй байдлыг хангах арга механизмууд
Цэрэндоржийн Батсүх	Инфляцийг хязгаарлах макро-эдийн засгийн бодлого

Эдгээр судалгаанаас бэлэн болсон 5 тайланг хэвлэх ажлыг ННФ хийж байгаа бөгөөд тайланд туссан зөвлөмжүүдийг бодлого, шийдвэрт тусгуулах нөлөөллийн ажлыг 2008 оны эхэнд хийж гүйцэтгэнэ. Бусад судлаачид тайлангаа боловсруулах эцсийн шатандаа орсон болно.

2007 оны хоёрдугаар хагаст бодлогын судалгааны хөтөлбөрийг дахин зарлаж, шинээр долоон судлаачийг сонгосон бөгөөд 2008 оны дундуур судалгаагаа дуусгахаар ажиллаж байна. Эдгээр судлаачдын нэр, судлаагын сэдвийг дорх хүснэгтээс харна уу.

Судалгааны сэдэв	Судлаач
ОНРТ-ийн бие даасан, хараат байдлыг бэхжүүлэх зорилгоор санхүүжилтийн механизмыг сайжруулах нь	Т.Батзориг, ОНРТ-ийн Радио нэвтрүүлгийн хэлстийн дарга
Төрийн албан хаагчийн Үр дүнгийн гэрээг хариуцлагын механизм болгон хэрэглэх боломж	Д. Оюунчимэг, “Мэдлэг, Хандлага” ТББ-ын тэргүүн
Төрийн салбарын цалингийн бодлогыг оновчтой болгох арга зам	Б. Хэрлэн, Удирдлагын Академийн Төрийн удирдлагын тэнхмийн ахлах багш
Тэтгэврийн даатгалын сангийн санхүүгийн болон удирдлагын бие даасан байдлыг бэхжүүлэх арга зам	Т. Одончимэг, Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
Нийгмийн даатгалын салбарт хувийн хэвшлийг хөгжүүлэх боломж	Ч. Дэлгэр “Монгол Судалгаа” компанийн гүйцэтгэх захирал
Даяаршлын нөлөө: гурил, буудайн үнийн талаар баримтлах бодлого	Ж.Уянга, МУИС-ийн Эдийн Засгийн сургуулийн багш
Төвлөрөл ихтэй хотын хүн амын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хангамжийг эрчимжсэн мал аж ауйг дэмжсэн тууштай бодлогоор шийдэх боломж	Ц. Батсайхан, Швейцарийн хөгжлийн хөтөлбөрийн хөдөө аж ахуйн мэргэжилтэн

ЭРДМИЙН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

Нээлттэй Нийгэм Форум 2007 онд Унгар улс дахь Соросын Сангийн Дээд Боловсролыг Дэмжих Хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй Эрдмийн тэтгэлэгт хөтөлбөрийн Монгол дахь үйл ажиллагааг зохицуулах ажлыг гүйцэтгэж эхэллээ. Уг хөтөлбөр нь гадаадын нэр хүндтэй их, дээд сургуулиудын магистр, докторын хөтөлбөрт амжилттай суралцаад ирсэн эрдэмтэн багш нарыг Монголын их, дээд сургуулиудад тогтвортой, үр бүтээлтэй ажиллахад нь төрөл бүрийн дэмжлэг үзүүлэх замаар нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухааны сургалтын хөтөлбөр, арга зүйг шинэчлэх, төгсгөгчдийн мэдлэг

чадварыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулах зорилготой юм.

2007-2008 оны хичээлийн жилд хөтөлбөрт МУИС-ийн Нийгмийн Ухааны сургуулийн Нийгэм, соёлын антроплогийн тэнхим, Эдийн Засгийн Сургуулийн Эдийн засгийн онолын тэнхим, МУБИС-ийн Нийгмийн ажилтны тэнхим, ЭМШУИС-ийн Нийгмийн Эрүүл Мэндийн Сургуулийн Эпидемиологийн тэнхимийн нийт 11 багш хамрагдлаа. Хөтөлбөрийн хүрээнд тэнхмүүд нь сургалтын хөтөлбөрийг шинэчлэх нэгдсэн төлөвлөгөө гарган гадаадын зөвлөх багшаас зөвлөгөө авч ажилласны

зэрэгцээ тэнхмийг хөгжүүлэх төсөл боловсруулахдаа нэмэлт дэмжлэг авах боломжтой байв. Зөвлөх багшийг Монголд ирж ажиллах үеэр сургалт, лекц зохион байгуулав. Тухайлбал, Эдийн засгийн онолын тэнхим зөвлөх Теодор Хорбуликтэй хамтран “Зардал, үр ашгийн тооцоо”, “Хөгжлийн эдийн засаг” сэдэвт лекцүүдийг 2007 оны 12 дугаар сард зохион байгуулав.

Түүнчлэн шинэчлэх шаардлагатай

ХЭВЛЭН НИЙТЛЭЛ

Эдүгээ Монголд бодлого боловсруулах болон түүний хэрэгжилтийг хянах, эрхээ хамгаалахад мэдлэг мэдээлэлтэй иргэдийн оролцоо нэн чухал болсон төдийгүй улс орны хөгжлийн бодлогод эерэгээр нөлөөлөх оролдлогууд цөөнгүй илрэх болжээ. Энэхүү оролцоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Нээлттэй Нийгэм Форум 2003 оноос эхлэн 100 гаруй ном, судалгааны тайлан, иргэдийн гарын авлага, ном зүйн цуврал, эдийн засаг, улстөр, ардчилал, иргэний нийгмийн хөгжлийн сэдвээр цөөнгүй ном хэвлэн гаргалаа.

Форумаас эрхлэн гаргасан эрх зүйн хөтөч, иргэний нийгмийн байгууллагын удирдахуй, мониторингийн гарын авлага, Монгол Улсын эдийн засгийн

хичээлийн хөтөлбөрүүд дээр багш нар зөвлөх болон Төв Ази, Төв болон Зүүн Европын орнуудын бусад багш нарын санал зөвлөгөө, дэмжлэгийг веб хуудсаар дамжуулан тогтмол хүлээн авч байна. Мөн гадаадын их, дээд сургуулийн номын санд ажиллах, олон улсын хурал зөвлөгөөнд оролцох зэрэг тодорхой тэтгэлгийг хоёр багш хүртэж, бусад нь хүсэлт гаргаад байна. Хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагаа англи хэл дээр явагддаг.

эрх чөлөөний тойм зэрэг ном хэвлэлүүд нь нэлээд эрэлт сайтай, олны танил бүтээгдэхүүн болж чадлаа.

Форум 2007 онд хөтөлбөрүүдийнхээ хүрээнд нийт 27 ном хэвлүүлснээс бодлогын судалгааны тайлан 9, иргэдэд зориулсан гарын авлага 6, үлдсэн хувийг ном зүйн цуврал, орчуулгын ном эзэлж байна. Эдгээр бүтээгдэхүүнээс заримыг дурдвал:

- Бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад ТББ-ын оролцоо /Бодлогын судалгааны тайлан/
- Парламентад бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь /Бодлогын судалгааны тайлан/
- Хууль боловсруулах, хэлэлцэх үйл явц дахь иргэдийн оролцоо /Олон

- улсын хурлын эмхтгэл/
- Эдийн засаг энгийнээр /Орчуулга/
- Монгол Улсын аж үйлдвэрийн салбарын өрсөлдөх чадварын үнэлгээ /Судалгааны тайлан/
- Монгол Улсын Эдийн засгийн эрх чөлөөний тойм /Судалгааны тайлан/
- Монгол Улсын татвар хураах механизм /Бодлогын судалгааны тайлан/
- Хүнсний аюулгүй байдалд холбогдох ном зүй
- ТББ-уудад зориулсан мониторингийн гарын авлага
- ТББ-уудад зориулсан татварын гарын авлага
- ТББ-уудад зориулсан төсвийн гарын авлага

- ТББ-ыг удирдахуй /Гарын авлага/
- Ерөнхий сайдууд ярьж байна /Цуврал илтгэл, хэлэлцүүлгийн тэмдэглэл/
- Хэвлэл мэдээллийн өөрөө зохицуулах механизм /Судалгааны тайлан/
- Төрийн ил тод байдал: Шударга сонгууль /Форумын эмхтгэл/

Шинээр хэвлэгдэн гарч буй ном, судалгааны тайланг аймаг, сумын 330 гаруй номын сан, нийтийн болон их дээд сургуулийн номын сан, төрийн бус байгууллагууд, УИХ-ын гишүүд, Форумын уулзалт хэлэлцүүлэгт оролцогчдод байнга түгээж байна.

ОРЧУУЛГЫН ТӨСӨЛ

Дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн алдартай зохиогчдын нийгэм, эдийн засаг, улстөр, хөгжлийн сэдвээр гарсан номыг эх хэлнээ орчуулж өөрийн орны иргэдэд хүргэх зорилгоор Нээлттэй Нийгэм Форум 2004 оноос эхлэн Орчуулгын төсөл хэрэгжүүлж байгаа билээ. Орчуулгын төсөл нь иргэдийн иргэний боловсролд тус нэмэр болоод зогсохгүй улмаар тодорхой асуудлуудаар нийгэмд өрнөж буй олон нийтийн хэлэлцүүлэгт оролцох мэдлэг, мэдээлэлтэй иргэдийн тоо нэмэгдэж төрийн үйлчилгээг чанаржуулж салбарын бодлогыг хүчирхэгжүүлэхэд

хувь нэмрээ оруулах чухал нөлөөтэй юм.

Уг төслийн хүрээнд 2004-2006 онд “МонСудар” хэвлэлийн газартай хамтран “Нээлттэй нийгэм түүний дайснууд”, “Төрийг бэхжүүлэх нь”, “Түүхийн төгсгөл ба Сүүлчийн хүн”, “Улс төрийн байгууламж” зэрэг 10 гаруй ном сонгон орчуулж хэвлэн олны хүртээл болгоод байна. 2007 онд “Ардчиллын дүр төрх: 36 орны засгийн хэлбэр ба хэрэгжилт” номыг орчуулж дуусган хэвлэлтэд шилжүүллээ.

БУСАД

“ДОРНО ДОРНО - ХИЛ ХЯЗГААРГҮЙ ТҮНШЛЭЛ” БҮСИЙН ХӨТӨЛБӨР

Дорно Дорно хөтөлбөр нь нээлттэй нийгмийг хөгжүүлэх, түүнийг бэхжүүлэх нөхцлийг бий болгоход чиглэсэн хүмүүсийн идэвх санаачилга, хамтын ажиллагаа, хил хязгааргүй түншлэлийг дэмждэг Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн бүсийн хөтөлбөр бөгөөд ННФ Монгол дахь үйл ажиллагааг нь хариуцан хэрэгжүүлж байна. Хөтөлбөр нь нээлттэй нийгмийн үзэл санааг бүсийн хэмжээнд бэхжүүлэхэд түлхэц болох шинэ санаа, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. Хоёр буюу түүнээс дээш орныг хамарсан төслүүдийг дэмждэг болно.

Энэхүү хөтөлбөр нь орон нутгийн нөхцөл байдлыг сайн мэдэрч дорноос гарч ирсэн санаачилгуудад анхаарлаа хандуулж, нээлттэй нийгмийг хөгжүүлэх нийтлэг зорилгод хүрэхийн тулд хүмүүс хил хязгаарыг харгалзахгүйгээр хүч хавсран ажиллах боломжийг нэмэгдүүлэхийг урт хугацааны зорилго болгодог юм. Хөтөлбөрийн хүрээнд бүсийн орнуудад зохиогдож буй шинэлэг санаа, арга туршлагаа хуваалцах зорилго бүхий арга хэмжээнд Монголын мэргэжилтэн, төлөөлөгчдийг хамруулж байна.

2007 онд Дорно-Дорно хөтөлбөрийн тэтгэлэгт хамрагдагсад

	Оролцогчдын нэрс	Байрлал	Хурал, семинар зохион байгуулагдсан газар болон агуулга	Огноо
1	Билгээгийн Сүхбаатар Мэдээлэл, Технологийн сургууль, тэнхмийн эрхлэгч	Ереван хот Армени улс	“Боловсролийн салбарт мэдээллийн технологийг нэвтрүүлэх нь” семинар	2007 оны 3 сарын 21-23
2	Бямбасүрэнгийн Эрхэмчимэг Мэдээлэл, Харилцаа, холбоо, технологийн газар, Бодлого төлөвлөлт хариуцсан ажилтан	Таллин хот Эстони улс	“Цахим-сонгуулиар дамжуулан иргэдийн оролцоог нэмэгдүүлэх замаар цахим ардчиллыг Монголд нэвтрүүлэх нь” Бага хурал	2007 оны 5 сарын 29-31

3	Жамсранжавын Чанцалдулам Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын ажилтан	Таллин хот Эстони улс	“Электрон-сонгуулиар дамжуулан иргэдийн оролцоог нэмэгдүүлэх замаар цахим ардчиллыг Монголд нэвтрүүлэх нь” Бага хурал	2007 оны 5 сарын 29-31
4	Аюушийн Батжаргал Шинжлэх Ухаан Мэдээллийн Төвийн дарга	Таллин хот Эстони улс	“Электрон-сонгуулиар дамжуулан иргэдийн оролцоог нэмэгдүүлэх замаар цахим ардчиллыг Монголд нэвтрүүлэх нь” Бага хурал	2007 оны 5 сарын 29-31
5	Жамьяанхорлоогийн Сүхбаатар Сонгуулийн хорооны гишүүн	Таллин хот Эстони улс	“Электрон-сонгуулиар дамжуулан иргэдийн оролцоог нэмэгдүүлэх замаар цахим ардчиллыг Монголд нэвтрүүлэх нь” Бага хурал	2007 оны 5 сарын 29-31
6	Пунцагийн Одончимэг Либерал эмэгтэйчүүдийн оюуны сангийн тэргүүн	Таллин хот Эстони улс	“Электрон-сонгуулиар дамжуулан иргэдийн оролцоог нэмэгдүүлэх замаар цахим ардчиллыг Монголд нэвтрүүлэх нь” Бага хурал	2007 оны 5 сарын 29-31
7	Сайнхүүгийн Ганбаатар Үйлдвэрчний Эвлэлийн дарга	Таллин хот Эстони улс	“Электрон-сонгуулиар дамжуулан иргэдийн оролцоог нэмэгдүүлэх замаар цахим ардчиллыг Монголд нэвтрүүлэх нь” Бага хурал	2007 оны 5 сарын 29-31
8	Бат-Эрдэнийн Батбаяр Зохиолч	Братислав хот Словак улс	“Популизм гэж юу вэ?” семинар	2007 оны 6 сарын 11-13
9	Бүдээгийн Мөнхтуяа УИХ-ын гишүүн	Бундестаг Герман	Иргэдийн оролцоо, Бундестагийн Иргэдийн өргөдөл гомдлын байнгын хороо: туршлага судлах аялал II	2007 оны 3 сарын 25- 4 сарын 01
10	Баясгалангийн Ганбат УИХ-ын Тамгын газрын 2- р нарийн бичгийн дарга	Бундестаг Герман	Иргэдийн оролцоо, Бундестагийн Иргэдийн өргөдөл гомдлын байнгын хороо: туршлага судлах аялал II	2007 оны 3 сарын 25- 4 сарын 01
11	Аюушцэрэнгийн Батпүрэв Инфорум төвийн гүйцэтгэх захирал	Баку, Азербайжан	Олборлох үйлдвэрлэлийн үзүүлж буй нөлөөнд тавих олон нийтийн хяналт, Олон улсын хурал	2007 оны 9 сарын 20-21

Дорно-Дорно хөтөлбөрийн хүрээнд ННФ-аас зохион байгуулсан семинар

№	Семинарын нэр	Байрлал	Огноо
1	Хууль боловсруулах, хэлэлцэх явц дахь иргэдийн оролцоо	Улаанбаатар Монгол	2007 оны 1 сарын 14-15
2	Стратегийн өмгөөлөл	Улаанбаатар Монгол	2007 оны 3 сарын 21-22

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нээлттэй Нийгэм Форум 2007 онд нийт 1,487,000 ам.долларын төсөвтэй ажилласан ба үүнээс 970,000 \$ Нээлттэй Нийгэм Хүрээлэн, 332,000 \$ Соросын сангийн сүлжээний хөтөлбөрүүд, 97,000 \$ Дэлхийн банк, 50,000 \$ Орлогын ажиглалтын хүрээлэн, 38,000 \$ нь бусад донор байгууллагаас санхүүжигдсэн болно. Төсвийн зарцуулалтыг доор хүснэгтээр харуулав.

Нийт зарцуулалт

ам. доллар

Хөтөлбөр	Үйл ажиллагааны зардал	Бусад байгууллагад олгосон тэтгэлэг	Нийт зардал
ЗАСАГЛАЛ	237,396	269,665	507,061
Ил тод байдал	49,952	25,331	75,283
Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө	4,097	80,852	94,949
Нээлттэй ил тод төсөв	33,772	-	33,772
Төрийн үйлчилгээний мониторинг	43,368	134,271	177,639
Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга	35,332	6,348	41,680
Иргэдийн оролцоо ба мэдээллийн эрх чөлөө	26,671	16,738	43,409
Стратегийн өмгөөлөл	17,008	3,996	21,004
Эрх зүйн туслалцаа	13,836	2,129	15,965
Төрийн бус байгууллагын эрх зүйн зохицуулалт	3,359	-	3,359
ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО	108,699	81,248	189,947
Эдийн засгийн эрх чөлөөний индекс	40,216	-	40,216
Монгол Улсын Өрсөлдөх чадвар	13,142	-	13,142
Орон нутгийн эдийн засгийн хөгжил	23,780	75,252	99,032
Уул уурхайн салбарын бодлогын асуудал	12,431	-	12,431
Хөгжлийн бодлогын яриа хэлэлцүүлэг	19,130	5,996	25,126
НИЙГМИЙН АСУУДАЛ	2,222	67,250	69,472
Боловсрол нийгмийн асуудлууд	2,222	67,250	69,472
ФОРУМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЯВУУЛАХ АРГА ХЭРЭГСЭЛ	151,659	32,434	184,093
Хөгжлийн мэдээллийн төв	55,049	-	55,049
Портал сайт	38,107	-	38,107
Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөр	52,422	32,434	84,856
Эрдмийн тэтгэлэгт хөтөлбөр	2,396	-	2,396
Орчуулгын хөтөлбөр	3,685	-	3,685
ЗАХИРГАА	229,663	-	229,663
НИЙТ ДҮН	729,639	450,597	1,180,236

Тэтгэлгийн зардал

ам. доллар

Хөтөлбөр	Төрийн бус байгууллагад олгосон	Төрийн байгууллагад олгосон	Хувь хүмүүст олгосон	Бусад байгууллагад олгосон
ЗАСАГЛАЛ	216,876	6,500	46,289	269,665
Ил тод байдал	11,740	6,500	7,091	25,331
Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө	66,869	-	13,983	80,852
Нээлттэй ил тод төсөв	-	-	-	-
Төрийн үйлчилгээний мониторинг	134,271	-	-	134,271
Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга	-	-	6,348	6,348
Иргэдийн оролцоо ба мэдээллийн эрх чөлөө	-	-	16,738	16,738
Стратегийн өмгөөлөл	3,996	-	-	3,996
Эрх зүйн туслалцаа	-	-	2,129	2,129
Төрийн бус байгууллагын эрх зүйн зохицуулалт	-	-	-	-
ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО	34,902	46,346	-	81,248
Эдийн засгийн эрх чөлөөний индекс	-	-	-	-
Монгол Улсын өрсөлдөх чадвар	-	-	-	-
Орон нутгийн эдийн засгийн хөгжил	34,902	40,350	-	75,252
Уул уурхайн салбарын бодлогын асуудал	-	-	-	-
Хөгжлийн бодлогын яриа хэлэлцүүлэг	-	5,996	-	5,996
НИЙГМИЙН АСУУДАЛ	66,072	1,178	-	67,250
Боловсрол, нийгмийн асуудлууд	-	-	-	67,250
ФОРУМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЯВУУЛАХ АРГА ХЭРЭГСЭЛ	-	-	32,434	32,434
Хөгжлийн мэдээллийн төв	-	-	-	-
Портал сайт	-	-	-	-
Бодлогын судалгааны тэтгэлэгт хөтөлбөр	-	-	32,434	32,434
Эрдмийн тэтгэлэгт хөтөлбөр	-	-	-	-
Орчуулгын хөтөлбөр	-	-	-	-
ЗАХИРГАА	-	-	-	-
НИЙТ ДҮН	317,850	52,846	79,901	450,597

Төрийн бус байгууллагуудад олгосон тэтгэлэг

ам. доллар

№	Тэтгэлэг хүртэгч	Тэтгэлгийн нэр	Дүн
1	Глоб Интернэшнл	Төрийн байгууллагуудын мэдээллийн нээлттэй ил тод байдалд хийх мониторинг	11,740
2	Глоб Интернэшнл	Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчлийн мониторинг ба хараат бус хэвлэл мэдээллийн эрхийг дэмжих нь	60,000
3	М.Эрдэнэбат	Эстон, Гүрж, Чех улсын олон нийтийн радио телевизийн туршлага судлах сургалт	3,870
4	М.Буянбадрах	Эстон, Гүрж улсын олон нийтийн радио телевизийн туршлага судлах сургалт	2,999
5	Газар Тариалан Хөгжүүлэх Сан	Газар тариалиангийн салбарт пестицидийн хэрэглээнд мониторинг хийх	10,482
6	Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхэдтэй Эцэг Эхчүүдийн Холбоо	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд хамруулах үйл явц, боловсролын шинэ хуулийн хэрэгжилтэд мониторинг хийх	10,218
7	Хувийн Мал Эмнэлгийн Холбоо	Төрөөс мал эмнэлгийн эм бэлдмэлийн зарцуулалтад зориулж буй санхүүжилтийг оновчтой болгох	9,102
8	Бор Өндөр загвар хотхон	Төлбөрийн орлогын мониторинг	10,510
9	Хүний Эрх- Хөгжил төв	Ашигт малтмалын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох үйл явцын мониторинг	7,880
10	Хөгжлийн Санаачилга, Бодлого Судлалын Төв	Эмнэлгийн мэргэжлийн лиценз олголтын мониторинг	4,361
11	Авилгатай тэмцэх сэтгүүлчдийн клуб ТББ	Авилгын эсрэг хуулийн хэрэгжилтийн мониторинг	14,047
12	МИДАС ТББ	Төрийн байгууллагуудын вэбсайтын мэдээллийн мониторинг	9,028
13	Монголын Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Байгууллагуудын Үндэсний Холбоо	Сонгоё, Сонгуулья	5,838
14	Филантропи Хөгжлийн төв	Эд хөрөнгө, түүнтэй холбоотой бусад эрхийн бүртгэлийн үйлчилгээнд хийх мониторинг	10,980
15	Сайн Үйлс ТББ	Нийгмийн халамж эзэндээ очихсон	7,837
16	Нийгмийн Халамж, Хамтын Ажиллагааны Сан	Тогтвортой Амьжиргаа Хөтөлбөрийн хэрэгжилт	6,006
17	Говь Алтай аймаг дахь Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүдийн Хөдөлгөөн	Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх хуулийн мониторинг	6,860

№	Тэтгэлэг хүртэгч	Тэтгэлгийн нэр	Дүн
18	Дархан уул аймаг дахь Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүдийн Хөдөлгөөн	Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдал	4,952
19	Зориг Сан	Засгийн газраас иргэдэд сургалтын тэтгэлэг, зээл олгох үйл ажиллагаанд хийх мониторинг	8,495
20	Айвуун ТББ	Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгай дансанд мониторинг хийх төсөл	3,000
21	Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхэд Залуучуудыг дэмжих “Гэгээ Мандал” Сан	Нийгмийн халамжийн тухай хуулийн холбогдох заалтуудын хэрэгжилтийн байдалд мониторинг хийх	4,675
22	Хөвсгөл Далайн эзэд	Хөвсгөл нуурт Дюбовский онгоцны хэрэгт стратегийн өмгөөлөл явуулах төсөл	3,996
23	Бодлого Судлалын Хүрээлэн	DELTA төсөл	34,902
24	Эрх Чөлөө төв ТББ	Хараагүй иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх сургалт	9,500
25	Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг	Нэмэлт тэтгэлэг	43,072
26	Боловсролын Зөвлөгөө Мэдээллийн төв	Нэмэлт тэтгэлэг	13,500
			317,850

Төрийн байгууллагуудад олгосон тэтгэлэг

ам. доллар

№	Тэтгэлэг хүртэгч	Тэтгэлгийн нэр	Дүн
1	Авилгатай Тэмцэх Газар	Төрийн байгууллагын үйлчилгээг ил тод болгох нь	6,500
2	Хөвсгөл аймгийн Тариалан сумын ЗДТГ	Сумын иргэдийн бизнесийн чадавхийг дээшлүүлэхэд чиглэгдсэн сургалтын нөхцөл бүрдүүлэх	10,200
3	Увс аймгийн Тариалан сумын ЗДТГ	Сумын төвийн гэрэлтүүлэг, хаягжилтыг сайжруулах, автозамыг тэмдэгжүүлэх, Ойн төгөл	10,150
4	Баянхонгор аймгийн Баянхонгор сумын ЗДТГ	Тарбозавр үлэг гүрвэлийн араг ясыг бэхжүүлэх, Баянхонгор хотын цахим, мэдээлэл сурталчилгааны төв байгуулах	9,600
5	Архангай аймгийн Ихтамир сумын ЗДТГ	Дэмид жанжны нэрэмжит цэцэрлэгт талбай байгуулах	10,400
6	Газрын Харилцаа, Геодези, Зураг зүйн Газар	“Сайн газрын харилцаа, түүний эдийн засгийн хөгжилд гүйцэтгэх үүрэг” Олон Улсын Бага Хурал	5,996
			52,846

Хувь хүмүүст олгосон тэтгэлэг

ам. доллар

№	Тэтгэлэг хүртэгч	Тэтгэлгийн нэр	Дүн
1	Д.Сүхгэрэл	Тайланд улсын сонгуулийг ажиглах сургалт	3,646
2	С.Оюунтуяа	Тайланд улсын сонгуулийг ажиглах сургалт	3,445
3	Г.Цэрэнпүрэв	Эстон, Гүрж улсын олон нийтийн радио телевизийн туршлага судлах сургалт	2,999
4	Х.Чилаажав	Эстон, Гүрж, Чех улсын олон нийтийн радио телевизийн туршлага судлах сургалт	4,218
5	Н.Золжаргал	Чех улсын олон нийтийн радио телевизийн туршлага судлах сургалт	1,767
6	Х.Наранжаргал	Урагвай улсад болсон IFEX 15 дахь хурал	2,000
7	Н.Содномдорж	Эстон, Гүрж улсын олон нийтийн радио телевизийн туршлага судлах сургалт	2,999
8	А.Батпүрэв	Азербайжан улсад болсон ОУИТБС талаар зохиогдсон олон улсын хурал	1,723
9	Э.Бямбажав	Казакстан улсад болсон ТББ-уудын бүсийн уулзалт	1,864
10	Ц.Ганболд	Казакстан улсад болсон ТББ-уудын бүсийн уулзалт	2,761
11	А.Батжаргал	Эстон улсын олон нийтийн радио телевизийн туршлага судлах сургалт	1,788
12	Б.Ганбат	ХБНГУ-д зохиогдсон Хууль боловсруулах, батлах, үйл явц дахь иргэдийн оролцоо хурал	2,180
13	Б.Мөнхтуяа	ХБНГУ-д зохиогдсон Хууль боловсруулах, батлах, үйл явц дахь иргэдийн оролцоо хурал	2,180
14	Ж.Сүхбаатар	Эстон улсын олон нийтийн радио телевизийн туршлага судлах сургалт	1,788
15	Ж.Чанцалдулам	Эстон улсын олон нийтийн радио телевизийн туршлага судлах сургалт	1,788
16	П.Одончимэг	Эстон улсын олон нийтийн радио телевизийн туршлага судлах сургалт	1,788
17	С.Ганбаатар	Эстон улсын олон нийтийн радио телевизийн туршлага судлах сургалт	1,788
18	Б.Баабар	Словак улсад болсон Популизмын талаарх олон улсын семинар	1,650
19	Б.Эрхэмчимэг	Эстон улсын олон нийтийн радио телевизийн туршлага судлах сургалт	1,788

№	Тэтгэлэг хүртэгч	Тэтгэлгийн нэр	Дүн
20	Л.Мөнхцэцэг	Их Британи улсад болсон олон улсын өмгөөлөгчдийн бага хурал	2,129
21	Б.Сүхбаатар	Армен улсад болсон IT семинар	1,178
22	Б.Хэрлэн	Төрийн байгууллагын цалин хөлс урамшууллын тогтолцоог оновчтой болгох нь	4,595
23	Ч.Дэлгэр	Нийгмийн даатгалын салбаруудын менежмент	4,307
24	Д.Н.Бурхинов	Халимагийн ард түмний цагаачлал ном	3,700
25	Д.Оюунчимэг	Төрийн байгууллагуудын үр дүнгийн гэрээ	3,550
26	Ж.Уянга	Монгол улсын гадаад худалдааны бодлогод даяаршлын үзүүлэх нөлөө	3,500
27	Н.Мягмарцоож	Төрөөс хяналт шинжилгээ хийх үүргээ гүйцэтгэхэд нь ТББ, иргэдийн оролцоог хангах арга замыг боловсруулах нь	4,532
28	Т.Батзориг	ОНРТ-ийн санхүүгийн хараат бус байдлыг хангах нь	4,700
29	Т.Одончимэг	Нийгмийн даатгалын салбаруудын менежмент	3,550
			79,901

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

Удирдах зөвлөлийн дарга:

П.Цэнгүүн ptsenguun@altantaria.mn

Удирдах зөвлөлийн гишүүд:

Д.Ганбат ganbat@academy.org.mn
Л.Төр-Од turod@khasbank.mn
Н.Туяа тuya05@yahoo.com
Х.Тэмүүжин temuujin@lawyer.com
Г.Уранцоож chrd@mongolnet.mn
С.Цэрэндорж s.tserendorj@nhrc-mn.org

Гүйцэтгэх захирал:

П.Эрдэнэжаргал jargal@forum.mn

Ажилтнууд:

Ж.Баярцэцэг	Засаглалын асуудал хариуцсан менежер	bayar@forum.mn
Н.Дорждарь	Эдийн засгийн асуудал хариуцсан менежер	dorjdari@forum.mn
Б.Мөнхсоёл	Эдийн засаг, Хэвлэл мэдээллийн асуудал хариуцсан менежер	soyoloo@forum.mn
А.Гэрэлмаа	Нийгэм, Боловсролын асуудал хариуцсан менежер	gerelmaa@forum.mn
Д.Энхцэцэг	Засаглалын асуудал хариуцсан менежер	enkhee@forum.mn
Д.Долгорсүрэн	Хөтөлбөрийн туслах ажилтан	fassistant@forum.mn
О.Оюунсаруул	Хөтөлбөрийн туслах ажилтан	passistant@forum.mn
Д.Балжид	Мэдээллийн төвийн менежер	baljid@forum.mn
Д.Баярмаа	Мэдээлийн төвийн туслах ажилтан	dircassist@forum.mn
Д.Гантуяа	Порталын ерөнхий редактор	gantuya@forum.mn
Д.Жавхлан	Санхүү, захиргааны захирал	javkhlan@forum.mn
Д.Аюуш	Нягтлан бодогч, тэтгэлэгийн менежер	ayush@forum.mn
Д.Өлзийбадрах	Мэдээлэл сүлжээний зохицуулагч	ulzii@forum.mn
Т.Отгонбаяр	Захирлын туслах	reception@forum.mn
Б.Баатар	Жолооч	baatar@forum.mn
Г.Цэдэвхүү	Жолооч	tsedev@forum.mn
Ч.Саруул	Жолооч	saruul@forum.mn
Ш.Ганчимэг	Захиргааны туслах ажилтан	ganaa@forum.mn

Нийтлэг Имэйль: osf@forum.mn

